



Эцсийн өмчлөлийг мэдээлэх санц, мөрдүүлгийг боловсруулах

Хангалттай, үнэн зөв, сүүлийн үеийн мэдээлэл олгуулах

Бодлогын танилцуулга

2022 оны 10-р сар (2022 оны 9-р сард англи хэл дээр хэвлэгдсэн)

Тойм 2

Санцны зорилго 6

Эцсийн өмчлөлийн ил тод байдлын дэглэм дэх санц тавих
зөрчлүүд 8

эцсийн өмчлөгчийн мэдээллийг мэдээлэх дэглэм дэх санцны
төрлүүд 11

Санц ноогдуулах этгээд 16

Санцыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх 21

Мөрдүүлэлтийг хэрэгжүүлэх 25

Дүгнэлт 27



Тойм

Хангалттай санкцыг хэрэгжүүлэн үр дүнтэй мөрдүүлсэнээр мэдээлэлд тавигдах шаардлагыг илүү сайн мөрдүүлж эцсийн өмчлөгчийн (ЭӨ) мэдээллийг үнэн зөв, хэрэглэгдэх боломжийг нэмэгдүүлэн баталгаажуулах механизмыг сайжруулна. Энэ нь мөн хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, татвараас зайлсхийх, авлига болон санхүүгийн бусад гэмт хэрэг үйлдэх зорилгоор зүй бусаар ашиглах сонирхлыг бууруулдаг. ЭӨ-н мэдээллийг мэдээлэх эрх зүйн үүрэг нь хамгийн үр дүнтэй арга боловч хүчтэй дүрэм, мөрдүүлэх дэглэмийг дагалдуулан хэрэгжүүлэхгүй бол үр дүнгүй байдаг нь сүүлийн үед хийсэн судалгаа, бодит жишээнээс харагддаг.^а

Мөнгө угаахын эсрэг (МУЭ) болон Терроризм санхүүжүүлэхтэй тэмцэх (ТСТ) олон улсын стандарт тогтоодог байгууллага болох Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) болон Европын Холбооны Мөнгө Угаахын Эсрэг Тавдугаар Захирамжаар (МУЭТЗ) улс орнуудаас ЭӨИТБ-н шаардлагыг хангаагүй этгээдэд “үр дүнтэй, тэнцвэртэй, урьдчилан сэргийлэх” санкц хэрэгжүүлэхийг шаарддаг.¹ Улс орнууд эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг (ЭӨИТБ) хир хэрэгжүүлж байгааг үнэлдэг 2013 оны ФАТФ-н Арга зүйн Даруй гарах Үр Дүн 5-н Шалгуур үзүүлэлт 5.6 нь мөн ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг мөрдөөгүй этгээдүүдийн эсрэг улс орнууд “үр дүнтэй, тэнцвэртэй, урьдчилан сэргийлэх” санкцыг хир хэрэгжүүлж байгааг үнэлэхийг шаарддаг.²

Ямартай ч “үр дүнтэй, тэнцвэртэй, урьдчилан сэргийлэх” санкцаас гадна ЭӨИТБ-н заалтуудыг зөрчүүлэхгүй байх мөрдлөгийн системийг хэрэгжүүлэхийг улс орнуудаас шаарддаг ч ФАТФ-н стандарт болон МУЭТЗ-д улс орнуудаар хэрэгжүүлүүлэх тодорхой арга хэмжээг тусгаж өгдөггүй. Энэ сэдэв дээр удирдамж, судалгаа, бичигдсэн зүйлс их байдаггүй нь бодлого гаргагч

хэрэгжүүлэгчдэд “үр дүнтэй, тэнцвэртэй, урьдчилан сэргийлэх” санкц гэдэг нь юу болох болон хэрхэн мөрдүүлэхийг тодорхой ойлгоход хүндрэл учруулдаг.

ФАТФ болон Эгмонт Группын 2019 онд хамтран явуулсан судалгаагаар үр дүнтэй, тэнцвэртэй, урьдчилан сэргийлэх санкц байдаггүй нь ЭӨИТБ-г хэрэгжүүлж буй орнуудад хамгийн их тулгарч буй бэрхшээлүүдийн нэг гэдгийг онцолдог.³ Нийцлийн ерөнхий соёл зэрэг хувьсагч хүчин зүйлс маш олон байдаг тул санкцын үр дүнг хэмжих болон санкц, нийцэл хоёрын харилцан хамаарлын шууд шалтгаан нөлөөг тогтооход бэрхшээлтэй байдаг. Мэдээллийг ихээр мэдээлж байгааг дан ганц санкцтай холбож ойлгох боломжгүй ч үүнийг ФАТФ-н зүгээс үр дүнтэй санкцтай холбосон байдаг ба санкц нь мөрдлөгийг хангуулахад чухал ач холболдолтой гэдэг нь энэхүү танилцуулгын байр суурь юм.⁴

Энэхүү бодлогын танилцуулгын зорилго бол ЭӨИТБ-д зориулан үр дүнтэй санкц хэрэгжүүлэх, мөрдүүлэх дэглэмийг бий болгох тал дээр бодлого гаргагч, хэрэгжүүлэгчдийн бодолцоо ёстой зарим гол зүйлсийг онцлон өөр өөр орнуудын хэрэгжүүлж эхэлж буй сайн туршлагыг тодорхойлж бодлогын гол зарчмуудыг таниулах явдал юм. Энэхүү танилцуулгад газарзүйн янз бүрийн байршилд байдаг орнуудын жишээг оруулахыг зорьсон ч ЭӨИТБ-н шинэчлэлийг анхлан хэрэгжүүлэгчид нь Барууны орнууд байдаг ба санкц, мөрдлөгийн талаар илүү их мэдээлэлтэй байдаг тул жишээний олонхи нь Барууны орнуудынх байгаа болно. Энэхүү танилцуулга нь ЭӨИТБ-н шинэчлэлийг хэрэгжүүлж буй бодлого гаргагч, хэрэгжүүлэгчдэд ЭӨИТБ-г бий болгох үр дүнтэй санкцын дэглэмийг тогтоохтой холбоотой янз бүрийн хуулийн, бодлогын, техникийн хүчин зүйлсийн талаар бодолцож үзэхэд тус болох зорилготой. Мөн мэдээллийг буруугаар

^а Жишээлбэл мэдээллийг сайн дураар бүртгүүлэх дэглэмийг нэвтрүүлсэн Олборлох Үйлдвэрийн Ил Тод Байдлын Санаачилгыг (ОУИТБС) хэрэгжүүлж буй орнуудын хувьд Англи зэрэг мэдээлэл өгөхийг хуулиар шаардсан орнуудтай харьцуулахад журам мөрдөлт бага байсан.



ашиглахаас урьдчилан сэргийлэх зэрэг ЭӨ-н санкцын дэглэмийн зарим нэмэлт зүйлс болон энэ талаарх зарим оронд өрнөж буй зүйлсэд товчхон дүн шинжилгээ хийнэ.

Санкцын дэглэмийг ямар нэг цоорхойгүй цогц байлгахын тулд дараах зүйлсийг оруулах нь зүйтэй:

- **бүх төрлийн мөрдлөгийн зөрчлийн эсрэг санкц, үүнд:**
 - ЭӨ-н мэдээллийг өгөхгүй байх;
 - хоцрогдуулах;
 - бүрэн бус өгөх;
 - буруу, хуурамч мэдээлэл өгөх;
 - давтан зөрчих;
- **мөнгөн торгуулийг хангалттай өндөр тавьж, ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг мөрдөхгүй байхыг бизнесийн үйл ажиллагааны хэвийн зардал мэтээрх ойлголт төрүүлэхгүй байх;**
- **мөнгөн торгуулиас илүү үр дүнтэй байж болох санхүүгийн бус санкц ба хувь хүн болон хуулийн этгээдийн (Хүснэгт 1-г үз); хоёулангийн эсрэг тавих эрүүгийн санкц;**
- **мэдэгдэл гаргахад холбогдсон бүх этгээдүүд болон компаний гол этгээдүүд ба тухайн компанийг хамрах санкцууд. Үүнд:**
 - эцсийн өмчлөгч(ид);
 - мэдэгдэл гаргаж буй этгээд;
 - компаний албан хаагчид; болон
 - хуулийн этгээд.

Ингэснээр зөрчил гаргагчдыг зөрчил үйлдээгүй гэж няцаах, мөн хариуцлага нэг этгээдрүү чихэх боломжгүй болгон ашиг сонирхол бүхий үйлдэгчдийн цар хүрээг өргөжүүлэн зөрчлөөс урьдчилан сэргийлэн мөрдөлтийг хангах боломжийг нэмэгдүүлдэг. Хэрэв ямарваа нэг орон гуравдагч талд ЭӨ-тэй холбоотой (мэдээлэл мэдээлэх эсвэл үнэн зөв мэдээлэл олгох үүрэг хариуцлага зэрэг) үүрэг ноогдуулсан бол үүрэг зөрчих эсвэл мөрдөөгүй үед тавих санкцын арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Мэдээлэл мэдээлэх системүүдэд байх дараах зүйлс нь санкцыг үр дүнтэй хэрэгжүүлж, мөрдөлтийг хангахад чухал хувь нэмэр оруулах боломжтой гэж үздэг:

- **Санкцыг мөрдүүлэх эрх бүхий байгууллагыг тодорхой тогтоож тухайн эрх бүхий байгууллагыг мөрдөн сурвалжлах, хууль сахиулах чиг үүрэг зэрэг санкцыг мөрдүүлэх хангалттай материал бааз, хуулийн эрх мэдлээр хангах;**

- **бүртгэгч болон прокурорын байгууллагын хооронд гэх зэргээр мөрдүүлэх үүрэгтэй байгууллагуудын хооронд мэдээллийг үр дүнтэй солилцох зохистой журам, процедурыг бий болгох;**
- **мэдээлэл мэдээлэхэд оролцож буй дотоодын хуулийн этгээдэд шаардлага тавих зэргээр дотоодын бус этгээд болон эцсийн өмчлөгчдийн талаарх мэдээллийг олгож буй хуулийн этгээдийг хянахад шаардлагатай хуулийн эрхийг тухайн байгууллагад олгох;**
- **хууль журмыг эс мөрдөх талаарх мэдээлэл нийтэлж ноогдуулсан санкцын талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгон компаниудын мөрдөлтийг нэмэгдүүлэх;**
- **боломжтой үед санкцын механизмыг автоматжуулах;**
- **хуурамч мэдээлэл өгсөнийг илүү сайн илрүүлэх баталгаажуулалтын хүчирхэг тогтолцоог бий болгох;**
- **захиргааны болон иргэний торгууль, санкцын эсрэг зарга үүсгэвэл буруугүйгээ нотлох үүрэг ноогдуулах**


ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг мөрдөөгүй үед хэрэгжих үр дүнтэй, тэнцвэртэй, урьдчилан сэргийлэх, мөрдүүлэх боломжтой санкцыг бий болгох нь Нээлттэй Өмчлөлийн Зарчмуудын (НӨЗ) үндсэн баримтлал юм.⁵ НӨ-н Зарчмууд нь ЭӨ-н мэдээллийг мэдээлэх үр дүнтэй стандартыг тогтоож сүүлийн үеийн, шалгалт хийж болох мэдээллийг⁶ нийтлэх аргуудыг тодорхойлдог ба үүний хүрээнд тэнцвэртэй, урьдчилан сэргийлэх санкцын хэрэгжүүлэлт болон үр дүнтэй мөрдүүлэлт нь мөрдөлтийг хангаж мэдээллийн чанарыг сайжруулахад маш чухал үүрэгтэй юм. НӨ-н Зарчмууд нь нийтэлсэн мэдээллийг ашиглах боломжтой, үнэн зөв, харилцан ажиллах боломжтой болгодог.

**Хүснэгт 1. Санкцуудын төрөл, зорилго**

Санкцын төрлүүд	Чиглэл: эцсийн өмчлөгч(ид)	Чиглэл: Мэдэгдэл гаргагч этгээд	Чиглэл: Хуулийн этгээдүүд	Чиглэл: Компаний алба хаагчид
Санхүүгийн Улс орны жишээ, үз Хуудас 12	<ul style="list-style-type: none"> – Захиргааны эсвэл иргэний торгууль – Давтан үл мөрдөлтөд торгуулийг нэмэгдүүлэх 	<ul style="list-style-type: none"> – Захиргааны эсвэл иргэний торгууль – Давтан үл мөрдөлтөд торгуулийг нэмэгдүүлэх 	<ul style="list-style-type: none"> – Захиргааны эсвэл иргэний торгуулийг орлогын хувиар тооцох – Давтан үл мөрдөлтөд торгуулийг нэмэгдүүлэх 	<ul style="list-style-type: none"> – Захиргааны эсвэл иргэний торгууль – Давтан үл мөрдөлтөд торгуулийг нэмэгдүүлэх
Санхүүгийн бус Улс орны жишээ, үз Хуудас 13	<ul style="list-style-type: none"> – Дараах эрхүүдийг хязгаарлах хязгаарлалтууд: <ul style="list-style-type: none"> – саналын эрх; – ноогдол ашиг хүртэх эрхийг түтгэлзүүлэх зэрэг хувьцаа; – зөвлөлд томилох эрх; – шинэ компани байгуулах 	<ul style="list-style-type: none"> – мэргэжлийн эсвэл бизнесийн тусгай зөвшөөрлийг цуцлах (жишээ нь нотариатч, хуульч, нягтлан бодогч, татварын зөвлөх г.м.) – Хуулийн этгээдийн өмнөөс мэдэгдэл гаргах эсвэл эрх хүлээн авахад хориг тавих 	<ul style="list-style-type: none"> – Албадан татан буулгах, идэвхгүй болгох, худалдааны бүртгэлээс компанийг хасах – Санхүүгийн байгууллагууд болон СББМҮҮБ бизнесийн харилцаагаа зогсоох – Ашиг тараах болон ноогдол ашиг тараахыг хориглох – Тусгай зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзах – Тусгай зөвшөөрөл, концессийг цуцлах – Засгийн газартай байгуулсан хүчин төгөлдөр гэрээг цуцлах – Засгийн газартай гэрээ байгуулах эрхгүй болгох – Компанийг идэвхгүйд тооцох 	<ul style="list-style-type: none"> – Аливаа хуулийн этгээдийн удирдлагад ажиллахыг хориглох, цуцлах – Бизнесийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглох
Эрүүгийн Улс орны жишээ, үз Хуудас 15	<ul style="list-style-type: none"> – Хуулийн этгээдэд санаатайгаар хуурамч мэдээлэл өгөх зэрэг ноцтой зөрчилд тавих эрүүгийн торгууль, хорих 	<ul style="list-style-type: none"> – Бүртгэлд санаатайгаар хуурамч мэдээлэл өгөх зэрэг ноцтой зөрчилд тавих эрүүгийн торгууль, хорих 	<ul style="list-style-type: none"> – Эрүүгийн торгууль 	<ul style="list-style-type: none"> – Бүртгэлд санаатайгаар хуурамч мэдээлэл өгөх зэрэг ноцтой зөрчилд тавих эрүүгийн торгууль, хорих



Зураг 1. эцсийн өмчлөгчийн ил тод байдлын санкцууд болон мөрдүүлэх дэглэмийн жишээ



Санкцын дэглэм нь бүх төрлийн нийцэл зөрчлийг (Хуудас 8-г үз) хамрах ёстой ба зөрчлийн ноцтой байдал, зорилгоос хамааран өөр өөр зөрчилд захиргааны, санхүүгийн, санхүүгийн бус болон эрүүгийн санкцуудтай (Хуудас 11-г үз) байх ёстой. Санкц нь мөн мэдээлэл мэдээлэхтэй холбоотой бусад үүргүүдийн эс мөрдөлтийг хамарч болно. (Хуудас 9-г үз). Санкц нь мэдэгдэл өгөхөд оролцсон бүх гол этгээдүүдийг хамрах ёстой (Хуудас 16-г үз). Хэрэгжүүлэгчид нь өөр өөр байгууллагуудын эрх үүргүүдийг тодорхой зааж өгөх зэргээр санкцын үр дүнтэй байдлыг (Хуудас 21-г үз) хангаж мөрдүүлэх (Хуудас 25-г үз) ёстой.



Санкцын зорилго

ЭӨ-н мэдээллийг мэдээлэх төвлөрсөн дэглэмд компаниудыг эцсийн өмчлөгчдийн мэдээллээ төрийн эрх бүхий байгууллагад өгөх эрх зүйн шаардлага багтсан байх ёстой. Эдгээр шаардлага нь эцсийн өмчлөгч гэж хэн болох;⁷ ямар хуулийн этгээд, хувь хүн мэдээлэл мэдээлэх үүрэгтэй;⁸ ямар мэдээллийг мэдээлэх ёстой;⁹ мэдээллийг хэзээ мэдээлэх ёстой зэргийг зааж өгнө. Мөн мэдээллийг хэн мэдээлэх эрх үүрэгтэй болохыг хуулиар зааж өгнө. Үүрэг хариуцлага нь тухайн хуулийн этгээдэд өөрт нь ноогддог хэдий ч зарим оронд мэдээллийг зөвхөн заагдсан гуравдагч талууд (нотариатч, хуульч г.м.) мэдээлэх эрхтэй байдаг.


Мэдээллийг ямар нөхцөл үүсэхэд мэдээлэх болон мэдээлэл хүлээн авах хугацааг эрх зүйн шаардлагад зааж өгөх ёстой. Хуулийн дагуу богино хугацааг зааж өгөх ёстой.¹⁰ Мэдээлэлд дараах зүйлс агуулагдах ёстой:

- хуулийн этгээдийн анх үүсгэн байгуулагдсан мэдээлэл;
- ЭӨ-д дараа нь орсон өөрчлөлтүүд: хэрэв өөрчлөлтийг мэдээлэхгүй бол нь ноцтой цоорхой болох тул бүх өөрчлөлтүүдийг мэдээлэхийг шаардах нь чухал юм (Зураг 2-г үз);
- хугацаа заах: дор хаяж жилд нэг удаа өгсөн мэдээлэл үнэн зөв болохыг баталгаажуулдаг байх.

ЭӨ-н санкцын дэглэмийн зорилго бол эрх зүйн шаардлагын мөрдөлтийг сайжруулж ЭӨ-н мэдээллийн чанарыг нэмэгдүүлэх замаар бүртгэлийн мэдээллийг “хангалттай, үнэн зөв, шинэчлэгдсэн” байлган баталгаажуулалтын механизмд дэмжлэг болгох.¹¹ Иймд бодлого гаргагч, хэрэгжүүлэгчдийн бодолцоо ёстой чухал зүйл бол ЭӨИТБ-н дэглэмийг үр дүнтэй байлгахын тулд ямар үйлдлийг санкцт оруулах ёстой вэ гэдгийг тодорхойлох юм. Энэ хэсэгт аливаа орны ЭӨИТБ-н дэглэмд оруулах ёстой санкц тавих зөрчлүүдийг танилцуулна. Мөн ЭӨ-н мэдээллийг хэрэглэгч зөв зохистой ашиглах талаар саяхан гаргасан асуудлуудыг онцлон энэ тал дээр санкц тавих зөрчлүүдийг хэлэлцэнэ.



Зураг 2. эцсийн өмчлөгчид өөрчлөлт орсон тохиолдолд мэдээлэх шинэчлэгдсэн



Энэ жишээнд А Компани нь X хувь хүнийг анх эцсийн өмчлөгчөөр бүртгэснээ мэдээлэв. Сүүлд Y хувь хүн X хувь хүний оронд компаний эцсийн өмчлөгч болжээ. Өөрчлөлтийг мэдээлэх ёстой хугацаа нь энэ оронд 14 хоног байна. Энэ хугацаанд А компаний эцсийн өмчлөгч нь Y хувь хүнээс Z хувь хүнрүү шилжив. ЭӨ-д орсон бүх өөрчлөлтийг мэдээлэх шаардлага байдаггүй байсан бол өмчлөлд эхний удаа өөрчлөлт ороход хугацаанд нь Z хувь хүнийг эцсийн өмчлөгчөөр мэдэгдсэн тохиолдолд Y хувь хүн хуулийн дагуу мэдээлэгдэхээс зугтан цоорхойг хууль бус зорилгоо хэрэгжүүлэхэд ашиглах боломжтой болох байсан гэсэн үг юм.



Эцсийн өмчлөлийн ил тод байдлын дэглэм дэх санкц тавих зөрчлүүд

Дараах үйлдлүүдийг ЭӨИТБ-н дэглэмийг эс мөрдсөнд тооцох ба мэдээлэл мэдээлэх дэглэмийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд тухайн орон санкц тавих ёстой.

Мэдээлэл өгөхгүй байх

Мэдээлэл өгөхгүй байх гэдэг нь хуулиар шаардсан хугацаанд мэдээлэл өгөхгүй байхыг хэлнэ. ЭӨ-н мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангахын тулд анх бүртгүүлэх үед ЭӨ-н мэдээллийг өгөөгүй тохиолдолд санкц тавина. ЭӨ-д орсон дараа дараагийн аливаа өөрчлөлтийг бүртгүүлээгүй бол санкц тавина. Дээр дурдсан цоорхойг хаахын тулд (Зураг 2-г үз) аж ахуйн нэгжийн ЭӨ-д орсон дараа дараагийн бүх өөрчлөлтийг бүрэн бүтнээр мэдэгдээгүй бол санкц тавина. Хамгийн хүчирхэг баталгаажуулалтын механизмын хувьд ч бүх өөрчлөлтийг мэдээлээгүйг илрүүлэхэд хэцүү байж болох ч аливаа хувь хүн эсвэл компани мэдээлэл өгөөгүй гэсэн нотолгоо нь мөрдөх ажиллагаанаас гарч ирж болно.

Жишээ нь Индонезийн хуульд ЭӨ-н мэдээллийг өгөөгүй бол санкц тавих заалт байдаг.¹² Гэсэн хэдий ч үүнийг амьдрал дээр хараахан хэрэгжүүлээгүй байгаа тул ЭӨ-н үнэн зөв, сүүлийн үеийн мэдээллийн чанар, хүртээмж дээр багтай биш гэсэн үг юм. 2021 оны 11-р сарын 28-ны өдрийн байдлаар Индонезийн засгийн газраас компаниудын 24.50% нь ЭӨ-н мэдээллийг өгсөн гэж мэдэгджээ.¹³

Мэдээлэл өгөөгүй бол санкц тавихаас өмнө нэг буюу түүнээс дээш анхааруулга, сануулгыг эрх бүхий байгууллага бий болгох талаар бодолцож үзэх ёстой ба ингэсний дараа мэдээллийг өгөөгүй хэвээр байвал илүү хүнд санкц тавьдаг байх ёстой. Эрх бүхий байгууллагад хариу өгөөгүй бол мөн санкц тавих хэрэгтэй.

Хоцорч өгөх

ЭӨ-н мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хангахын тулд анх бүртгүүлэхэд болон ЭӨ-н мэдээлэлд сүүлд өөрчлөлт орсон тухай бүр заасан хугацаанд ЭӨ-н мэдээллийг өгөлгүй хоцрогдуулсан бол санкц тавих ёстой.

ЭӨ-н мэдээллийг жил бүр баталгаажуулахыг шаарддаг орнууд мөн баталгаажуулалт хийгээгүй эсвэл хоцрогдуулсан тохиолдолд санкц тавих ёстой. Жилийн эцэст ЭӨ-н мэдээллийг баталгаажуулах хугацааг тухайн орон бизнесийн процесст оруулсан ч гэсэн тодорхой зааж өгөх ёстой (жишээ нь жилийн татварын тайлантай хамт г.м). Мэдээллийг ямар үед хоцорч баталгаажуулсан эсвэл баталгаажуулаагүйд тооцож санкц тавих эсэх дээр тодорхой удирдамж байх ёстой. Хугацааг тогтоохын тулд ЭӨ эсвэл компаний хууль журмын бусад заалтуудыг мөрдлөг болгон үр дүнг нийцэмжийг хангах; жишээ нь ЭӨ-н мэдээлэлд орсон өөрчлөлтийг шинэчлэх хугацааг заах г.м. Жишээ нь Украинд жилийн эцсээс хойш 14 хоногийн дотор ЭӨ-н мэдээллийг шинэчлэх ёстой байдаг.¹⁴ Англид хуулийн этгээдүүдээс жил бүр баталгаажуулалтын тодорхойлолтоор дамжуулан Компаний Хэлтэст ЭӨ-н мэдээллийг баталгаажуулахыг шаарддаг ба үүнийг сүүлийн 12 сарын хугацаа дууссанаас хойш 14 хоногийн дотор хийнэ.

Хоцорч өгөх хугацаа нь боломжийн хүрээнд аль болох богино байх ёстой; жишээ нь өгөх хугацаанаас хойш хуанлийн 14 хоногийн дотор ба үүнээс хойш бол баталгаажуулалтыг хийгээгүйд тооцох. ФАТФ-аас дээрх хугацааг Зөвлөмж 24-төө “зохистой хугацаа” гэж заадаг ч үүнээс цааш тайлбар өгөөгүй байна.¹⁵ Канадын иргэний нийгмийн санал болгосон хуулийн төсөлд хуулийн этгээдүүдийг эцсийн өмчлөгчдөөс өөрсдөөс нь тодорхойлох мэдээлэл, гэрчилгээний хуулбар гаргуулах 30-с 90 хоногийн хугацааг хэлэлцсэн байдаг ба үүнийг баталгаажуулалтын механизм гэж үзжээ.



Дутуу мэдээлэл өгөх

Анх бүртгүүлэхэд болон дараа нь өөрчлөлт орох үед ЭӨ-н мэдээллийг дутуу өгсөн тохиолдолд санкц тавих замаар ЭӨ-н мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хангуулах ёстой. Ингэснээр хуулийн этгээдүүд бүртгэлд бүрэн мэдээлэл өгөх сонирхлыг нэмэгдүүлнэ.

Жишээлбэл Францад дутуу мэдээлэл өгөх, мэдээллийг хоцорч өгсөн тохиолдолд тодорхой бизнесийн үйл ажиллагаа эрхлэхийг хорих эсвэл шүүхийн хяналтанд оруулах зэргээр үндэсний иргэний тодорхой эрхээс нь хасдаг. Үүнээс гадна дээрх үйлдлийг гаргасан хувь хүнийг 6 сар хорьж 7,500 еврогоор (ойролцоогоор 8,200 ам.доллар) торгодог. Мөн мэдээллийг хоцорч эсвэл дутуу өгсөн компани нь хувь хүний торгуулийг тав дахин төлөх хариуцлага хүлээнэ.¹⁶

Буруу эсвэл хуурамч мэдээлэл өгөх

ЭӨ-н мэдээллийг хуурамчаар өгөх эсвэл хуурамч мэдээллийн эх баримт өгвөл санкц тавих ёстой. Эцсийн өмчлөгчдийн зүгээс хуулийн этгээдэд хуурамч мэдээлэл өгсөн бол санкц тавина. Бусад мэдээллийн эх сурвалжтай харьцуулан шалгаж байгаа үед буруу эсвэл хуурамч байж болох мэдээллийг илрүүлэхэд туслах баталгаажуулалтын сайн систем байх шаардлагатай. Бусад зөрчлийн адил хуурамч мэдэгдэлд ноогдуулах санкц нь баталгаажуулалтын үйл явцад дэмжлэг болно.

Гэсэн хэдий ч холбогдох санкцуудыг тогтооход бодолцож үзэх ёстой чухал бодлогын асуудал бол хуурамч мэдээллийг зориудаар өгсөн үү эсвэл санаандгүй алдаа гаргасан уу гэдгийг ялгаж салгах уу, тийм бол хэрхэн ялгаж салгах вэ гэдэг юм. Сүүлийн үеийн туршлагаас харахад ЭӨ-н хуурамч мэдээллийг аливаа хувь хүн эсвэл хуулийн этгээд зориуд өгсөн (тусалсан) тохиолдлыг хайхрамжгүйгээр өгсөн тохиолдолтой харьцуулахад илүү хүнд шийтгэл ноогдуулж байна. Жишээлбэл Австри улсад санаатай зөрчлийг 200,000 Еврогоор (ойролцоогоор 220,000 ам.доллар), хайхрамжгүй зөрчлийг 100,000 Еврогоор (ойролцоогоор 110,000 ам.доллар) торгох боломжтой. Үүнтэй ойролцоогоор Филиппин улсад бүртгэлийн байгууллагад “санаатайгаар” хуурамч мэдээлэл өгсөн (ЭӨ-г санаатайгаар нуусан) хуулийн этгээд эсвэл эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдэд болон тэдгээр байгууллагын мэдээлэл нэгтгэн ирүүлэх үүрэгтэй этгээдүүдэд нилээдгүй торгууль ноогдуулдаг.¹⁷ Хуурамч мэдээллийг санаандгүй биш санаатайгаар өгсөнийг нотлох нь хэцүү бөгөөд ийм үйлдлийг амжилттай шийтгэсэн тохиолдол маш цөөн байдаг. Хуурамч мэдээллийг санаатайгаар өгсөнийг нотлох баримтыг хууль сахиулах байгууллагын мөрдөх үйл ажиллагаагаар олж авч болно.

Нүд 1: Английн компанийн захирал компаний талаар хуурамч мэдээлэл өгсөн хэрэгт буруутгагдсан тохиолдол¹⁸

2018 онд Англид компаний талаар хуурамч мэдээлэл өгсөн хэрэгт компаний захирлыг амжилттай холбогдуулж ялласан байдаг. Гэвч тухайн хувь хүн цоорхой байгааг олон нийтийн өмнө харуулсан.¹⁹

Энэ хэргийн хувьд компаний захирал нь 2013, 2016 онуудад хоёр компани байгуулахдаа захирал, хувьцаа эзэмшигчдийн талаар хуурамч мэдээлэл өгчээ. Компаний Хэлтэс тус хоёр компанийг татан буулгаж бүртгэлээс хассан байдаг. Мөн тус компаний захиралд арга хэмжээ авч тэрээр Английн компаний бүртгэлд хуурамч мэдээлэл өгсөн хэрэгт буруу хүлээж шүүхийн тогтоолоор 12,000 фунт стерлингийн торгууль төлжээ.

Давтан зөрчих

Улс орнууд ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг давтан биелүүлээгүй тохиолдолд тавих санкцын талаарх зохих заалтуудыг хуулиндаа оруулах хэрэгтэй. Жишээлбэл Австри улсад ЭӨ-н мэдээллийг удаа дараа өгөөгүй тохиолдолд ЭӨ-н мэдээлэл мэдээлэх дэглэмийн хүрээнд хоёр удаа шахалт өгөх торгууль ноогдуулдаг.²⁰ Грек, Англи зэрэг бусад орны ЭӨ-н мэдээллийг мэдээлэх дэглэмд давтагдсан зөрчилд ноогдуулах торгуулийг нэмэгдүүлэх ойролцоо заалтууд байдаг.

Мэдээлэл мэдээлэхтэй холбоотой нэмэлт үүргүүдийг эс мөрдөх

Аливаа орон ЭӨ-н мэдээллийг мэдээлэх дэглэмдээ гуравдагч талд хамаарах бусад заалтуудыг оруулсан бол эдгээр талуудад хариуцлага хүлээлгэдэг байх, мөн үүргээ биелүүлээгүй тохиолдолд тавих тэнцвэртэй, урьдчилан сэргийлэх санкцуудтай байх нь чухал. Бусад холбогдох талуудаар эдгээр заалтуудыг мөрдүүлэн үр дүнтэйгээр хэрэгжүүлдэг байх нь чухал юм. Үүнд жишээ нь МУЭТЗ-д шаардсанаар үүрэг хүлээсэн байгууллагуудад өөрсдийн хийсэн судалгаагаар олсон мэдээлэл болон төвлөрсөн бүртгэлд байгаа ЭӨ-н мэдээлүүдийн хооронд зөрөөтэй зүйл байвал мэдэгдэх шаардлага тавих зэргээр хувийн хэвшилд үүрэг хүлээлгэх зэрэг орно.



Бусад санкц тавих зөрчлүүд

Дээрх үйлдлүүдээс гадна цөөн орон ЭӨ-н дэглэмдээ ЭӨ-тэй холбоотой санкц тавих зөрчлүүдийг заасан байдаг. Үүнд жишээ нь ЭӨ-н мэдээллийг буруугаар ашиглахгүй байх арга хэмжээ орно. ЭӨ-н мэдээллийг буруугаар ашиглах тохиолдолд жишээ нь мэдээллийг арилжааны зорилгоор ашиглах; хэн нэгэнд хор учруулах зорилгоор мэдээлэл тараахад ашиглах; эсвэл тодорхойлох мэдээллийг хулгай хийх зорилгоор гэмт хэрэгтнүүдэд мэдээллийг худалдах, өгөх. Ийм төрлийн хууль нь мэдээллийг олон нийтэд нээлттэй болгоход бүр илүү чухал байдаг ЭӨ-н мэдээллийг мэдээлэх үйл явцад чухал хамааралтай хувийн нууцлал буурахаас үүсэх эрсдэлүүдийг бууруулахад тус болох ч яг ийм нөлөө гарах эсэх нь одоогоор тодорхойгүй юм.²¹ Энэ асуудал энэхүү танилцуулгын гол зорилго биш ч ийм зөрчлийг ЭӨ-н мэдээллийг мэдээлэх дэглэмдээ оруулах талаар хэрэгжүүлэгч, бодлого гаргагчид бодолцож үзэхэд нь сануулах нь зүйтэй юм.

Бүртгэл дээрх ЭӨ-н мэдээллийг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилготой заалтууд байгаа тохиолдолд үүнийг мөрдлөг болгохын тулд ЭӨ-н мэдээлэлд нэвтрэх үйл явцад шалгалт хийх боломжтой байхаас гадна тогтмол шалгалт хийдэг байх ёстой. Өөр нөхцөлд хэдий ч ийм аргыг Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллагын (ЭЗХАХБ) Тайлангийн Нийтлэг Стандартад оруулсан байдаг ба татвар төлөгчийн талаарх цуглуулсан мэдээллийг зүй бусаар мэдээлсэн, ашигласан тохиолдолд санкц, шийтгэл ногдуулахыг улс орнуудаас шаарддаг.²⁴

Нүд 2: эцсийн өмчлөгчийн мэдээллийг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх санкцууд

Австри улсад, ЭӨ-н бүртгэлд зөвшөөрөлгүй нэвтэрвэл 30,000 еврогоор (ойролцоогоор 32,500 ам.доллар), ЭӨ-н мэдээллийг гуравдагч талд тараавал 50,000 еврогоор (ойролцоогоор 54,100 ам.доллар) торгож шийтгэдэг.²²

ЭӨ-н бүртгэлийг хэрэгжүүлж буй Америкийн Нэгдсэн Улсын хувьд (АНУ) ЭӨ-н мэдээллийг зөв зохисгүйгээр мэдээлэх эсвэл ашиглавал иргэний болон эрүүгийн шийтгэл ноогдуулдаг. Компаний Ил Тод Байдлын Хуульд (КИТБХ) КИТБХ-иар зөвшөөрөөгүй тохиолдолд КИТБХ-н дор Сангийн Яамны Санхүүгийн Гэмт Хэргийг Хянах Сүлжээнд (FinCEN) өгсөн тайлангаас олж авсан эсвэл FinCEN-ий мэдээлсэн ЭӨ-н мэдээллийг санаатайгаар мэдээлэх, ашиглахыг хориглодог. Мэдээллийг зөвшөөрөлгүй мэдээлсэн эсвэл ашиглан КИТБХ-г зөрчсөн этгээдэд тухайн зөрчил гарсаар байгаа эсвэл засч залруулаагүй хоног тутамд 500 ам.долларын иргэний торгуулийг ноогдуулах хариуцлага хүлээлгэх ба торгууль нь 250,000 ам.доллар хүртэл нэмэгдэх, 5 жил хоригдох эсвэл хоёулаа үйлчлэх боломжтой.²³



ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ МЭДЭЭЛЭХ ДЭГЛЭМ ДЭХ САНКЦЫН ТӨРЛҮҮД

Энэ хэсэгт дээр дурдсан ЭӨ-н мэдээллийг мэдээлэхтэй холбоотой өөр өөр зөрчлүүдэд хамаарах санкцуудын төрлийг тоймлон олгох ба улс орнуудын жишээг оруулж ЭӨИТБ-г хангах зорилгод ямар ашиг тус авчирч байгааг хэлэлцэнэ. Эдгээр санкцуудыг аливаа орны ЭӨ-тэй холбоотой хуульд (Албани, Австри, Люксембург зэрэг) эсвэл ЭӨ-н хуулиас гадуурх шийтгэлийн хуулинд (Индонез, Итали зэрэг) оруулж болно. Англид эрүүгийн санкцыг анхдагч хуулиар, захиргааны санкцыг хоёрдогч хуулиар зохицуулсан байдаг Энэ нь тухайн орны эрх зүйн тогтолцооноос хамаарах боловч санкцыг аль болох анхдагч хуулиар зохицуулж захиргааны торгуулийг өөрчлөхөд илүү хялбар хоёрдогч хуулиар зохицуулах нь зүйтэй юм.

Санкцыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд эрх бүхий байгууллагуудыг эдгээр санкцуудыг ямар нэг хослолоор хэрэгжүүлэх эрх, боломжоор хангах нь улс орнуудын хувьд чухал юм. Ерөнхий зарчмын хувьд санкцуудыг бизнесийн энгийн зардлын нэг хэсэг гэсэн сэтгэгдлийг төрүүлэхгүйн тулд санхүүгийн болон санхүүгийн бус шийтгэлүүдийг багтаах хэрэгтэй. Ингэснээр санкцуудыг илүү үр дүнтэй, урьдчилан сэргийлэхүйц, тэнцвэртэй болгоно.



Санхүүгийн санкцууд

Санхүүгийн санкцууд нь ЭӨ-н мэдээлэл мэдээлэх шаардлагыг үл нийцэхэд эрх бүхий байгууллагуудаас ноогдуулдаг захиргааны болон эрүүгийн^b торгуулиуд байна. ЭӨИТБ-н шаардлагыг үл биелүүлэхэд ноогдуулдаг торгуулиуд нь улс орнуудын хооронд өөр өөр байна:

Хүснэгт 2. Улс орнуудын санхүүгийн санкцуудын түвшнүүдийн жишээ

Улс орон	Санхүүгийн санкц
Малави ²⁵	USD 0.35
Казахстан ²⁶	USD 7.00
Малайз ²⁷	USD 12–USD 140
Гана ²⁸	USD 350
Албани ²⁹	EUR 2,000–EUR 4,000 (ойролцоогоор USD 2,200–USD 4,400)
Монтенегро ³⁰	EUR 3,000–EUR 20,000 (ойролцоогоор USD 3,300–USD 22,000)
Франц ³¹	хувь хүнд EUR 7,500 (ойролцоогоор USD 8,200), хуулийн этгээдэд EUR 37,500 (ойролцоогоор USD 41,100)
Бельги ³²	EUR 250–EUR 55,000-н (approximately USD 275–USD 60,300) захиргааны торгууль ба EUR 400–EUR 40,000-н (USD 440–USD 44,000) эрүүгийн торгууль
Словени	EUR 6,000–EUR 60,000 (ойролцоогоор USD 6,600–USD 66,000)
Либериа ³³	Хувь хүнд USD 100,000, компанид USD 1,000,000
Австри	EUR 200,000 (ойролцоогоор USD 220,000)
Ирланд ³⁴	хөнгөн хэрэгт EUR 5,000 (ойролцоогоор USD 5,500), эрүүгийн хэрэгт ялласан бол EUR 500,000 (ойролцоогоор USD 550,000) ^c
Люксембург ³⁵	EUR 1,250–EUR 1,250,000 (ойролцоогоор USD 1,370–USD 1,370,000)
Герман ³⁶	EUR 1,000,000 (ойролцоогоор USD 1,100,000) хүртэл эсвэл тухайн зөрчлөөс олж авсан эдийн засгийн давуу талыг хоёр дахин нугалсан хэмжээ

Болгар, Хорват, Эстони, Франц, Либериа зэрэг нэлээн хэдэн орнуудад хувь хүн, хуулийн этгээдэд ноогдуулах санхүүгийн санкц нь өөр буюу хуулийн этгээдэд илүү өндөр торгууль тавьдаг. Санхүүгийн санкц нь өндөр талдаа хэдий ч хууль бус үйл ажиллагаа явуулж буй

этгээдүүдийн хувьд боломжийн зардал байж болно. ³⁷ Иймд дэглэмдээ санхүүгийн бус болон эрүүгийн санкц оруулахыг улс орнуудад зөвлөдөг. ³⁸

^b Захиргааны торгууль гэдэг нь буруу үйлдэлд холбогдох эрх бүхий байгууллагаас тавьсан, хууль журманд заасан, захиргааны зөрчил болох санхүүгийн торгуулийг хэлнэ. Захиргааны торгууль нь буруу үйлдлийг шийтгэх бус улсад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх гол зорилготой байдаг тул эрүүгийн торгуулиас өөр юм.

^c Ирланд болон Англи зэрэг зарим бусад оронд журиггүйгээр доод шүүхийн шүүгчийн шийддэг зөрчлийг хөнгөн хэрэгт тооцох ба эрүүгийн хэргийн хувьд шүүгч, жюри нар хэргийг хянан хэлэлцэнэ. Хөнгөн хэрэг нь эрүүгийн хэргээс хөнгөн бөгөөд үүнийг өөр өөр дүрэм журам, доод хэрэг хянан шийдвэрлэх удирдамжийн дагуу шийтгэдэг.



Санхүүгийн бус санкцууд

Үр дүнтэй хэрэгжилтийг бий болгохын тулд улс орнууд ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд санхүүгийн бус санкц тавих хэрэгтэй. ЭӨ-н мэдээллийг мэдээлэх дэглэмийн мөрдөлтийг сайжруулахыг зорьж буй улс орнуудын бодолцож үзэх ёстой санхүүгийн бус зарим санкцуудад дараах орно:

Бүрдүүлэх нөлөө

Бүрдүүлэх нөлөө гэдэг нь бүртгэл, мэдээлэх үйл явц нь өөрөө эрх үүсгэдэг гэсэн үг юм.³⁹ Энэ нь энэ танилцуулгад хэлэлцсэн бусад санкцуудын адилшийдгэл биш ч үүнтэй ойролцоо нөлөө үзүүлэх чухал заалт болно. Бүрдүүлэх нөлөөний хүрээнд ЭӨ-н мэдээллийг өгөөгүй, шинэчлээгүй бол компани дахь тодорхой эрхийг хэрэгжүүлэхэд нь хязгаарлалт тогтоодог.

Тухайн оронд бий болгосон ЭӨ-н бүртгэл дээр ЭӨ-н мэдээллийг бүртгүүлэх, шинэчлэх үйл явцыг дэмжихийн тулд (Австри, Уругвай зэрэг)^d цөөн хэдэн орон бүртгэлийг Бүрдүүлэх нөлөөтэй байхаар буюу ЭӨ-н мэдээллийг бүртгүүлсэнээр компани дахь эрхүүд нь үүсэхээр зохицуулалт хийсэн байдаг. ЭӨ нь өөрөө Бүрдүүлэх нөлөөгүй байна: аливаа хувь хүн нь эцсийн өмчлөгчийн статусыг мэдээлсэн, үгүйгээс үл хамааран компаний эцсийн өмчлөгч байна. Гэхдээ үнэн зөв, сүүлийн үеийн мэдээллийг өгөхөд компаний өмчлөлтэй холбоотой тодорхой ашгууд үүсэхээр зохицуулалт хийж болно. Жишээ нь бүртгэгдээгүй эцсийн өмчлөгч эсвэл хувьцаа эзэмшигчийн санал өгөх, ноогдол ашиг хүртэх эрхийг хасч болно. Жишээлбэл Уругвайд эцсийн өмчлөгчөө мэдэгдээгүй компанийг хувьд ашиг тараах нь хориотой байдаг.⁴⁰ Гэхдээ эдгээр зохицуулалтыг гаднаас нь мөрдүүлэх нь бэрхшээлтэй.

Бүртгэл дээрх мэдээллийг шинэчилдэггүй бол бүртгэл дээр байгаа захирал нь албангушаалаасаа буусан байсан ч гэсэн ЭӨ-н мэдээллийг мэдээлэхтэй холбоотой зөрчилд хариуцлага хүлээж боломжтой. Мэдээлэл нь бүртгэл дээр байхгүй бол шинэ захирлуудын гаргасан аливаа шийдвэрийг хүчингүйд тооцож болно. Захиргааны ийм санкц нь бүх талуудад мэдээллээ бүртгүүлэх, шинэчлэх хөшүүрэг болно.

Компаниудад ноогдуулах санхүүгийн бус санкцууд

Үүнд: компанийг үүсгэн байгуулахгүй байх; тодорхой тусгай зөвшөөрлийг олгохгүй, сунгахгүй байх (Малави);⁴¹ санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг ЭӨ-н төв бүртгэл дээр мэдээллээ бүртгүүлээгүй эсвэл шинэчлээгүй аж ахуйн нэгжтэй бизнесийн харилцаа тогтоох эсвэл гүйлгээ хийхийг хориглох (Умард Македон); хүчин төгөлдөр байдлын жилийн гэрчилгээг түтэлзүүлэх (Уругвай ба Филиппин); тусгай зөвшөөрөл, концессийг цуцлах, дуусгавар болгох (Камерун, Колумб, Индонез, Казахстан, Киргиз, Филиппин).

Хэрэв компани нь зохих ёсоор бүртгүүлээгүй бол хуулийн хэрэгслийг хуулийн хувьд үүссэн эсвэл хөрөнгө эзэмших, бизнесийн үйл ажиллагаанд оролцох чадамжтай болсон гэж үзэхгүй.⁴² Жишээ нь Словакт компанийг ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг зөрчсөнөөс нь болоод Бүртгэлийн Шүүх Улсын Түншлэлийн Бүртгэлээс хассан бол тухайн компаний засгийн газартай байгуулсан хүчинтэй гэрээнүүдийг цуцалдаг ба компани нь засгийн газартай гэрээ байгуулах боломжгүй болдог.⁴³

Умард Македоны ноогдуулсан санкц нь санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг төвлөрсөн ЭӨ-н бүртгэл дээр ЭӨ-н мэдээллийг оруулаагүй, шинэчлээгүй аж ахуйн нэгжтэй бизнесийн харилцаа тогтоох, үргэлжлүүлэхийг хориглодог. Энэхүү санкц нь бүртгэлийг мэдээлэл, баримт бичиг хадгалах газар гэхээсээ илүү бодит цаг дээрх шалгаж байх ёстой ач холбогдол бүхий мэдээллийн сан болгоход чухал үүрэгтэй юм. Зөрүүтэй мэдээллийг мэдээлэх шаардлагыг хэрэгжүүлж байгаа бол энэ хоёр шаардлага нь хоорондоо хэрхэн хамаарч ажиллахыг бодолцох нь чухал юм.

Албадан татан буулгах эсвэл бүртгэлээс хасах

ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг мөрдөөгүй компаниудыг татан буулгах, идэвхгүй болгох аргыг зарим орон хэрэглэдэг. Жишээ нь Дани улсын Бизнесийн Ерөнхий Газар нь ЭӨ-н мэдээллийг бүртгүүлээгүй эсвэл хангалттай өгөөгүй Данийн компанийг албадан татан буулгах эрхтэй байдаг. Дани улсад бүртгүүлэх ёстой түншлэл болон хязгаарлагдмал түншлэлүүдийг

^d Гүрж улс худалдааны бүртгэл дээрх (ЭӨ-н бус) үндсэн мэдээллийг үнэн зөв, сүүлийн үеийн байлгахын тулд хэрэгжүүлж буй санкц. Үндсэн мэдээлэлд оруулсан өөрчлөлт нь Гүржийн Төрийн Бүртгэлийн Үндэсийн Агентлагт бүртгүүлсэний дараа хүчин төгөлдөржинө. Бүртгүүлээгүй өөрчлөлтүүд нь хуулийн хувьд хүчингүй байна. Нэмэлт мэдээллийг дараахаас авна уу: Мөнгө Угаах, Терроризмыг Санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээнүүд: Гүрж – Хамтын Үнэлгээний 5-р Тайлан (Strasbourg: MONEYVAL Secretariat, 2020 оны 9-р сар), <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/mer-fsrb/MONEYVAL-Mutual-Evaluation-Georgia-2020.pdf>.



ЭӨ-н мэдээллийг өгөөгүй эсвэл хангалттай өгөөгүй тохиолдолд Бизнесийн Төв Бүртгэлээс хасч болно. ⁴⁴ Ийм заалт нь Бүрдүүлэх нөлөөтэй ба бүртгэлээс компанийг хассанаар компани татан буугдаж хуулийн этгээдийн эрхгүй болж байгаа юм. Жишээлбэл Латви улсад 2019 онд ЭӨ-н мэдээллийг өгөөгүй 400 компанийг Аж Ахуйн Нэгжийн Бүртгэлээс хасчээ. ⁴⁵ ЭӨ-н мэдээллийг бүртгүүлэх үүргээ биелүүлээгүй байгууллагуудыг бүртгэгч нь шүүхээр татан буулгах ажиллагаанд оруулах ойролцоо заалт Белгийн хуульд байдаг. ⁴⁶

ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг мөрдөөгүй хуулийн этгээдүүдийг бүртгэлээс хасах санкцын эрхийг эрх бүхий байгууллагад олгох нь журам мөрдөлтийг нэмэгдүүлэхээс гадна мэдээллийг цэвэрлэн баталгаажуулалтыг сайжруулахад чухал үүрэгтэй юм. 2021 оны 11-р сарын 28-ны өдрийн байдлаар Индонез улсын компаниудын 24.5% нь ЭӨ-н мэдээллийг өгсөн гэж тус улсын засгийн газраас мэдэгджээ. ⁴⁷ Тус мэдэгдлээр компаний багагүй хувь нь чимээгүй байсаар байх боловч бүх төрлийн компанийг бүртгэлээс хасах эрх нь бүртгэлд байхгүй ажээ. Ийм нөхцөл байдлыг шийдэхийн тулд компанид сануулга өгч хасах эрхийг бүртгэгчид өгөх замаар үнэн зөв, сүүлийн үеийн ЭӨ-н мэдээллийг хангах ёстой.

Ямартай ч бүртгэл нь энэхүү эрхээ мэдээлэл өгөх шинэ шаардлагад хэрэгжүүлэхдээ болгоомжтой байх ёстой. Кени улсад жишээлбэл олон компани идэвхгүй байдаг тул ЭӨ-н бүртгэлийг шаардлагын хангалт бага (30-35%) байдаг. ⁴⁸ Гэхдээ аль эрт байгуулагдсан зарим компаниудын хувьд шаардлагатай түүхийн бүртгэл байхгүй байдаг ба идэхтэй компаниудад компаний талаарх чанартай, түүхэн мэдээлэл болон компаний ЭӨ-н өөрчлөлтийн талаарх мэдээлэл шаардлагатай байдаг тул e-бүртгэлийн системрүү нүүхэд хүндрэлтэй байдаг гэжээ. ⁴⁹

ЭӨ-н мэдээллийг хугацаанд нь өгөөгүй эсвэл баталгаажуулаагүй аливаа хуулийн этгээдэд сануулга илгээх ёстой. Үндэслэл бүхий шалтгаан өгч чадаагүй бол тухайн компанийг идэвхгүйд тооцон идэвхтэй байгууллагуудын жагсаалтаас хасах хэрэгтэй. Санкцын ийм заалт нь компаниудыг ЭӨ-н бүртгэлээ тогтмол шинэчлэх хөшүүрэг болно. Санхүүгийн байгууллага (СБ) болон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг (СБМҮҮБ) бүртгэл дээрх идэвхтэй байгууллагуудын жагсаалтыг тогтмол шалган харилцагч байгууллага нь идэвхтэй тул харилцаж болох (банкны данс нээх, мөнгө шилжүүлэх, гэрээ байгуулах г.м.) эсэхийг шалгадаг байх шаардлагыг тавих ёстой. ⁵⁰ СБ болон СБМҮҮБ-г бүртгэл дээр идэвхгүй байгаа аж ахуйн нэгжтэй бизнесийн харилцаа тогтоох, үргэлжлүүлэхийг хориглох ёстой. Үүнийг

холбогдох эрх бүхий байгууллагуудын хяналт шалгалтын хүрээнд СБ болон СБМҮҮБ-аар бизнесийн харилцаа тогтоох болон хянах үүргийн хүрээнд харилцагчаа таньж мэдэх шаардлагыг мөрдүүлдэгтэй адилаар мөрдүүлэх боломжтой.

Компаний удирдах албан тушаалтанд ноогдуулах санкцууд

Үүнд жишээ нь: эрүүгийн хэрэг үүсгэх; компани нь ЭӨ-н үүргийг зөрчсөн бол компани байгуулах эсвэл удирдах албан тушаал хашихыг хориглох (Испани, Франц); бизнесийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах (Франц); эсвэл “үндэсний болон иргэний эрхийг нь хязгаарлах” (Франц) г.м. ⁵¹ Испанид ЭӨ-н мэдээллийг мэдээлэх үүргээ зөрчсөн компаний хувьд компаний захирлуудыг ямар ч компанид тухайн албан тушаалаа хаших эрхийг дээд тал нь 5 жилээр хасдаг. ⁵² Хэрэв (хуульч, нягтлан бодогч, траст болон компаний үйлчилгээ үзүүлэгч зэрэг) мэргэжлийн байгууллага аливаа хуулийн этгээдэд тодорхойлох мэдээллийг нуухад дэмжлэг үзүүлсэн бол тухайн байгууллагад санкц тавих хэрэгтэй; үүнд эрүүгийн хэрэг үүсгэх, мэргэжлийн, бизнесийн тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцох г.м орно. Энэ тохиолдолд тухайн мэргэжлийн өөрийгөө зохицуулах байгууллагад (хуульч, нотариатч, нягтлан бодогч) хангалттай чадамж, материал баазыг олгосон тохиолдолд сахилгын арга хэмжээний хүрээнд санкц тавихад чухал үүрэг гүйцэтгэх боломжтой. ЭӨ-н мэдээллийг мэдээлэх дэглэмийг зуучаар дамжуулан хэрэгжүүлдэг орнуудын хувьд ийм санкцууд нь ач холбогдолтой байна. Эдгээр орнуудын хувьд мэргэжлийн эрх ямба зэрэг журам мөрдөлт, мөрдүүлэлтэд саад болж болох зуучуудад хамаарах эрх зүйн орчны асуудлуудыг анхааралдаа авах ёстой.

Эрх зүйн болон захиргааны орчинд санхүүгийн бус санкцуудыг нэвтрүүлэхэд бодолцож үзэх ёстой чухал зүйл нь санхүүгийн бус санкцуудыг ЭӨИТБ-н бодлогын зорилтуудтай уялдуулан аль болох урьдчилан сэргийлэх шинж чанартай болгох явдал юм. Жишээ нь худалдан авалтын бүртгэлийн хувьд ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг мөрдөөгүй хувь хүн, хуулийн этгээдийг засгийн газартай гэрээ байгуулах эрхийг хасч болно. Словак улсад ийм заалт байдаг ба компаниудыг 3 жил хүртэлх хугацаагаар төртэй гэрээ байгуулахыг хориглож Төрийн Ашиг Сонирхолын Бүртгэлтэй холбоотой хуулийн шаардлагыг мөрдөөгүй бол 1 сая хүртэлх Еврогоор торгодог. Англид төрийн худалдан авалтын бүртгэлд иймэрхүү ойролцоо арга хэмжээ авах талаар хэлэлцэж байгаа ба ЭӨ-н мэдээллийг өгөөгүй бол эрхийг нь хасч жагсаалтанд оруулах талаар авч үзэж байна. ⁵³



Эрүүгийн санкц

Санхүүгийн болон санхүүгийн бус захиргааны санкцуудаас гадна улс орнууд ЭӨИТБ-н шаардлагуудыг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдүүдэд (хуулийн этгээдийн хувьд тухайн улсын эрх зүйн системээс шалтгаалах, доор дэлгэрэнгүй танилцуулсан) эрүүгийн санкц ноогдуулах хэрэгтэй. Эрүүгийн санкцыг санаандгүй алдаагаар бус санаа зорилготойгоор ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг ноцтойгоор болон давтан зөрчсөн үед тавих нь зүйтэй юм. Эрүүгийн санкцид ЭӨИТБ-н дэглэмийн шаардлагыг зөрчсөн хувь хүнийг хэдэн сараас хэдэн жил хорих орно. Жишээлбэл Камерун улсад ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг зөрчсөн хувь хүнийг 3 сар хүртэл; Франц, Голландад дээд тал нь 6 сар; Англид 2 жил хүртэлх хугацаагаар; Замбиад 5 жил хүртэлх хугацаагаар; Польшид 8 жил хүртэлх хугацаагаар хорьж болно.

Эрүүгийн санкциудыг санхүүгийн санкцтай харьцуулахад ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг мөрдүүлэхэд илүү үр дүнтэй гэж үзэх хандлага их.⁵⁴ Ямартай ч тухайн хувь хүний санаа зорилгыг нотлон эрүүгийн санкц тавихад хүндрэлтэй учраас улс орнууд эрүүгийн санкцыг дэглэмдээ оруулдаггүй эсвэл эрүүгийн хэргийн торгуулиар журмаар оруулдаг. Эрүүгийн санкцыг оруулсан орнуудын хувьд ч ял, хэрэгжүүлэлтийн талаар хангалттай мэдээлэл одоогоор байхгүй байна. Өмнө дурдсанчлан санаатай хуурамч мэдээлэл өгсөн хэрэгт амжилттай ял өгсөн цөөн хэдэн хэрэг бий.

АНУ-д ЭӨ-н үнэн биш мэдээллийг сайн дураар 90 хоногийн дотор засч залруулсан бол санкц тавихгүй байх аргыг санал болгож буй.⁵⁵ Энэ нь тухайн үнэн биш мэдээллийг өгөхдөө шаардлагаас бултах гэсэн санаа агуулаагүй эсвэл үнэн биш гэдгийг нь мэдээгүй үед үйлчлэх нөхцөлтэй байдаг тул санаа зорилготой байсан гэдгийг харуулахад мөн адил бэрхшээлтэй юм. Энэ арга нь ЭӨ-н мэдээллийг санаандгүйгээр дутуу, буруу өгсөн тохиолдолд гэмгүй талуудыг хамгаалах зорилготой гэж харагдаж байна. Ямартай ч ийм аргыг улс орнууд хэрэгжүүлэхдээ маш болгоомжтой байх хэрэгтэй ба учир нь энэ нь нэмэлт цаг хожих цоорхой болох боломжтой юм. Мөн ЭӨ-н мэдээллийг анх ямар зорилгоор буюу санаандгүйгээр, хайхрамжгүй байдлаар, санаатайгаар үнэн бишээр өгсөн эсэхийг тогтооход хариуцагч эрх бүхий байгууллагын хувьд хэцүү байж болно.



Санкц ноогдуулах этгээд

Санкцын хууль батлахдаа бодлого гаргагч, хэрэгжүүлэгч нар ЭӨИТБ-н санкцийг хэнд ноогдуулах ёстой вэ гэдгийг бодолцож үзэх ёстой. Аливаа хуулийн этгээдтэй холбоотой талууд болон тухайн хуулийн этгээдийн эсрэг санкц тавихад харьцангуй сайн зүйлс бий. Гэхдээ эдгээр бүх талуудын эсрэг санкц тавих замаар зөрчил үйлдэгчдэд няцаалт хийх, хэн нэгэнрүү хариуцлагаа чихэх боломжгүй болгон журмыг мөрдүүлэх ашиг сонирхол бүхий үйлдэгчдийн цар хүрээг өргөжүүлж зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэрэгтэй. Мэдэгдэлтэй холбоотой бүх гол үйлдэгчдийн журам мөрдөлтийг хангахын тулд санкцыг хувь хүн (эцсийн өмчлөгч, мэдэгдэл гаргасан этгээд, компаний бүртгэгдсэн албан тушаалтан) болон хуулийн этгээдийн (мэдэгдэл гаргасан компани) эсрэг тавих ерөнхий зарчмыг баримтлах нь чухал юм.

Эцсийн өмчлөгч(ид)

Журмын мөрдөлтийг эцсийн өмчлөгчдөөр хангуулж ЭӨ-н шаардлагатай мэдээллийг үнэн зөвөөр өгөх тал дээр хуулийн этгээдтэй хамтран ажиллуулахын тулд эцсийн өмчлөгчдийг ЭӨ-н санкцын дэглэмд оруулах нь чухал юм. МУЭТЗ-н хэрэгжүүлж буй энэ аргын хүрээнд хуулийн этгээдэд ЭӨ-н мэдээллийг мэдээлэх дэглэмийг мөрдөхөд шаардлагатай мэдээллээр хангах үүргийг эцсийн өмчлөгчид ноогдуулах хийгээд энэ үүргээ зөрчсөн тохиолдолд “үр дүнтэй, тэнцвэртэй, урьдчилан сэргийлэх” арга хэмжээ, санкцыг тавихыг гишүүн орнуудаас шаарддаг.⁵⁶ Хэрэв бодит эцсийн өмчлөгч бус нэр дэвшигчийг санаатайгаар эцсийн өмчлөгч гэж мэдэгдсэн бол тухайн санкцыг нэр дэвшигчид хамруулж болно. Тухайн хувь хүн тухайн үйлдэлд санаатайгаар оролцсон бол санкцыг ноогдуулж болно; жишээ нь тухайн хувь хүн нь үүнийг сайн дураар, санаатайгаар төлбөрөөр гүйцэтгэсэн бол г.м. Гэхдээ тухайн хувь хүнд мэдэгдээгүй эсвэл шахалтаар нэр дэвшүүлсэн бол санкцыг ноогдуулахгүй байж болно.

Эцсийн өмчлөгчдөд санкц ноогдуулах заалтуудыг Австри, Люксембург, Польш зэрэг ЕХ доторх хэд хэдэн орон болон Английн ЭӨ-н мэдээллийг мэдээлэх дэглэмд оруулсан байдаг. эцсийн өмчлөгчдөд ноогдуулах ёстой болон ноогдуулдаг санкцын төрлүүдэд дараах орно:

Санхүүгийн санкцууд

Люксембургэд бүртгэгдсэн аж ахуйн нэгжид ЭӨ-н мэдээллийг мэдээлэх үүргээ биелүүлэхэд нь хэрэг болох мэдээлэл, баримт бичгийг өгөөгүй тохиолдолд эцсийн өмчлөгчид 1,250,000 еврогийн (ойролцоогоор 1,370,000 ам.доллар) санхүүгийн санкц ноогдуулна.⁵⁷

Санхүүгийн бус санкцууд

Үүнд жишээ нь ноогдол ашиг хүртэх, санал өгөх эрхийг түтгэлзүүлэх зэргээр тухайн эцсийн өмчлөгчийн хувьцаа, эрхийг хязгаарлах байж болно (Энэтхэг, Польш, Англи). Мэдээлэл олгоогүй эсвэл хуурамч мэдээлэл олгосон үед эцсийн өмчлөгчдөд санкц тавих эрхийг компаниудад өгөх заалтыг холбогдох ЭӨ-н мэдээллийг мэдээлэх хуульд оруулж өгч болно.

Эрх зүйн системээсээ шалтгаалан хэрэгжүүлэгчид нь аливаа компани тогтоол батлах замаар дотроо энэхүү шийдвэрт хүрэх үү эсвэл ийм тушаалыг шүүхэд хандаж гаргуулах шаардлагатай юу гэдгийг тодорхойлох ёстой. Жишээ нь Англид эцсийн өмчлөгчдийн эрхийг “хязгаарлах мэдэгдэл”-н нөлөөллийг Нөлөө бүхий эзэмшигч этгээдүүдийн бүртгэл 2016 болон Компаний Хууль 2006-д заасан байдаг ба компаний дүрэмд заалт байхгүй ч компани хэрэгжүүлэх боломжтой байдаг.⁵⁸ Английн хуульд компаний зүгээс холбогдох ЭӨ-н мэдээллийг өгөх хоёр хүсэлтэд эцсийн өмчлөгч хариу өгөөгүй бол тухайн компани нь эцсийн өмчлөгчид хязгаарлах мэдэгдлийг өгч тухайн хувь хүний ашиг сонирхлыг (хувьцаа, санал өгөх эрх, зөвлөлийн томилох эрх) царцаах арга хэмжээ авч болно гэж заасан байдаг. Аливаа компани нь ЭӨ-өө хамтран ажиллаагүй гэж мэдэгдээд л хариуцлагаас зугтаах боломжгүй байх арга хэмжээг хэрэгжүүлэгчид авах ёстой ба эдгээр санкцууд



хир үр дүнтэй байх нь тухайн санкц хуулийн этгээдийн эсрэг санкц зэрэг бусад санкцуудтайгаа хэр уялдаж байгаагаас хамаарна.

Санхүүгийн бус санкцууд нь тухайн компани нь өөрийгөө зохицуулах сонирхолтой, эцсийн өмчлөгч нь тухайн аж ахуйн нэгжид хувь эзэмшдэг тохиолдолд тухайн эцсийн өмчлөгчийн эсрэг үр дүнтэй байж болно. Харин тухайн компани нь бүхэлдээ хууль бус үйл ажиллагаа явуулах зорилготойгоор байгуулагдсан халхавч компани бол эсвэл эцсийн өмчлөгч нь тухайн аж ахуйн нэгжийг албан өмчлөлөөр биш албан бусаар удирдан хянадаг тохиолдолд сайтар үр дүн гарахгүй.

Үүнтэй ойролцоо заалтууд АНУ-н банкны хуульд байдаг ба банкны хуулийг ноцтойгоор зөрчсөн тохиолдолд “байгуулагатай холбоотой талууд”-г банкны

хяналтын байгууллага албан тушаалаас нь захиргаадан чөлөөлдөг.^е Эдгээр санкцуудыг үр дүнтэйгээр мөрдөх эсэх нь хяналтын салбараас шалтгаална. Унгар улсын авсантай ойролцоо өөр нэг арга (Нүд 3-г үз) нь эцсийн өмчлөгч нь төвлөрсөн бүртгэлд мэдэгдэх ёстой ЭӨ-н мэдээллийг өгөөгүй тохиолдолд хэрэг болж болно. Эцсийн өмчлөгчдийн эсрэг санкц тавихаас гадна тухайн компанийг ЭӨ-н бүртгэлд “тодорхойгүй” эсвэл “найдаргүй” гэж тэмдэглэн эрх бүхий байгууллагууд болон мэдээлэх байгууллагуудад анхааруулж зохих шалгалт, арга хэмжээг авахуулуулах нь зүйтэй юм. Ийм мэдээллийг Харилцагчийн Судалгааны (ХС) хүрээнд мэдээлэх байгууллагад мэдэгдсэнээр тэд бүртгэлд мэдэгдэнэ. Энэ нь хуулийн этгээдийг өөрийгөө зохицуулах, нэр төрийн хувьд үүсч болох үр дагавруудыг бууруулах хөшүүрэг болно.

Нүд 3: Унгар дахь “тодорхойгүй” эсвэл “найдаргүй” хуулийн этгээдүүд⁵⁹

2021 оны 5-р сарын 22-ны өдөр хүчин төгөлдөр болсон Унгарын ХЛII Хуульд (Эцсийн Өмчлөгчийн Бүртгэлийн Хууль буюу Афад хууль гэх) хуулийн этгээдүүдийг ТТ буюу арван оноо бүхий найдварын оноогоор үнэлдэг. Хуулийн этгээд бүр нь арван оноотой эхлэнэ. Хэрэв Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн дагуу аливаа эрх бүхий байгууллага, улсын прокурор, шүүх болон бусад мэдээлэх аж ахуйн нэгж өөрт байгаа мэдээлэл болон ЭӨ-н төв бүртгэлд оруулсан мэдээлэл хоёрын хооронд ноцтой зөрүү илрүүлбэл ЭӨ-н бүртгэлийг хөтлөх эрх үүрэг бүхий байгууллага болох Унгарын Үндэсний Татвар, Гаалийн Захиргаанд мэдэгдэж болно.

Татварын алба нь тухайн мэдээлэлд үндэслэн тухайн хуулийн этгээдийн ТТ оноог өөрчилнө. Мэдээллийг хэн өгсөнөөс шалтгаалан (эрх бүхий байгууллага эсвэл өөр үйлчилгээ үзүүлэгч) тухайн хуулийн этгээдийн ТТ оноог нэг юмуу хоёр оноогоор хасна. Наймаас доош ТТ оноотой хуулийн этгээдийг “тодорхойгүй” гэж тэмдэглэх ба зургаагаас доош

орвол “найдаргүй” гэж тэмдэглэнэ. Өөрчлөлт оруулсаны дараа тухайн хуулийн этгээдэд мэдэгдэх ба өөрчлөх боломж олгох 5 хоногийн хугацаа өгнө.

ЭӨ-н Бүртгэлийн Хуульд “тодорхойгүй” эсвэл “найдаргүй” хуулийн этгээдүүдэд мөнгөн санкц тавих заалт байдаггүй боловч бусад санкцууд байдаг. Үүнд:

- Нэгдүгээрт “найдаргүй” гэж тэмдэглэгдсэн хуулийн этгээдүүдийн нэрийг татварын албаны вебсайт дээр нийтэлнэ. “Тодорхойгүй” гэж тэмдэглэгдсэн хуулийн этгээдүүд нь 180 хоногийн дотор мэдээллээ зохих ёсоор шинэчлэх замаар 10 оноогоо буцааж авахгүй бол мөн нийтэлнэ.
- Хоёрдугаарт Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн хүрээнд (хуульч, банк, халамжийн үйлчилгээ үзүүлэгч зэрэг) бүх мэдээлэх байгууллагуудыг “найдаргүй” харилцагчтай мөнгө угаах эрсдэл өндөр учраас 4.5 сая форинтоос (ойролцоогоор 13,000 ам.доллар) хэтэрсэн гүйлгээ хийхийг хориглодог.

^е АНУ-н Холбооны Депозит Даатгалын Хууль, хэсэг 8(е). “Байгуулагатай холбоотой тал” гэдэгт бусад этгээдээс гадна ФАТФ-н Стандартын дагуу эцсийн өмчлөгчтэй тэнцэхүйц банк удирдан хянадаг этгээдийг хэлнэ.



Эрүүгийн санкц

Англид жишээ нь эцсийн өмчлөгч мэдээлэл олгоогүй бол эрүүгийн хэрэгт тооцон хоёр жил шоронд хорих, торгууль ноогдуулах, эсвэл хоёулангийн хэрэгжүүлэх арга хэмжээ авдаг. Францын 2020-115 Захирамжаар хуулийн этгээдэд зохих хугацаанд шаардлагатай мэдээлэл олгоогүй эсвэл үнэн зөв биш, дутуу мэдээлэл олгосон эцсийн өмчлөгчид эрүүгийн санкц ноогдуулах буюу зургаан сар хорьж 7,500 еврогоор (ойролцоогоор 8,200 ам.доллар) торгодог байна. АНУ мөн ойролцоо арга санал болгодог ба Компаний Ил Тод Байдлын Хуулийн дагуу ЭӨ-н үүргийг зөрчвөл 10,000 ам.долларын торгууль ноогдуулж 2 жил хүртэл хорино.⁶⁰

Мэдүүлэг гаргагч этгээд

Мэдүүлэг гаргагч этгээд нь шаардлагатай ЭӨ-н мэдээллийг бүртгэлд мэдэгддэг буюу бүртгүүлдэг. Энэ хүн нь хуулиас шалтгаалан хувь хүн эсвэл санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага (СББМҮҮБ) байж болно. Мэдүүлэг гаргагч этгээд нь эцсийн өмчлөгч өөрөө байж болох ч олон тохиолдолд (хуульч, аудитор, консултант зэрэг) компаний зөвлөх эсвэл зарим орны хувьд бүртгэлд өгөх ЭӨ-н мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулах шаардлагатай нотариатч байж болно.

ЭӨ-н мэдээллийг нээлттэй байлган хугацаанд нь үнэн зөвөөр шинэчилж байхын тулд хуулийн этгээдүүдийг тухайн оронд оршин суугч нэг буюу түүнээс дээш тооны хувь хүнд эсвэл СББМҮҮБ-д ЭӨ-н шаардлагатай мэдээллийг өгөх эрхийг олгохыг⁶¹ янз бүрийн олон улсын стандартаар шаарддаг.⁶² Олон оронд эдгээр стандартуудын дагуу ЭӨ-н шаардлагатай мэдээллийг бүртгэлд мэдээлэх эрхийг тухайн оронд оршин суугч этгээдэд өгөхийг шаарддаг. Ийм аргыг ЭӨ-н мэдээллийг мэдээлэх дэглэмийг гадаадын хуулийн этгээдүүдээр мөрдүүлэхэд ялангуяа хэрэгтэй гэж үздэг. Ямартай ч мэдээллийг илүү үр дүнтэйгээр мэдээлүүлэхийн тулд санкцуудыг компаний төлөөлөгч зэрэг эдгээр эрх бүхий эсвэл мэдүүлэг гаргагч этгээдэд ноогдуулан ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг зөрчсөнд нь хариуцлага хүлээлгэдэг байх нь чухал юм.⁶³

Гэхдээ ЭӨ-н шаардлагатай мэдээллийг мэдээлэхэд (хуульч, нягтлан бодогч, нотариат зэрэг) гуравдагч тал оролцсон бол бүртгэлд өгөхийн өмнө ЭӨ-н хуурамч мэдээллийг хүлээн авсанаа мэдээгүй байсан бол тухайн гуравдагч талд хариуцлага хүлээлгэх үү гэсэн асуулт гардаг. Словак зэрэг зарим оронд гуравдагч талуудад мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээлгэх замаар баталгаажуулалтыг хангадаг (Нүүд.4-г үз). Харин эсрэгээрээ Украйнд нотариатчид мэдээллийн үнэн зөв эсэхийг тогтооход хүндрэл учруулах боломжтой хуулийн

этгээдүүдийн олгосон хуурамч мэдээллийг бүртгэлд өгсөнөөс болж хариуцлага хүлээн санкц тавиулахыг хүсэхгүй байсан тул ийм системийг дэмжихгүй байжээ.

Ийм нөхцөлөөс урьдчилан сэргийлэхийн тулд гуравдагч талын олгосон ЭӨ-н мэдээлэлтэй холбоотой зарим урьдчилсан нөхцөлийг хуульд оруулах замаар санкцыг үр дүнтэй байлгаж болно. Жишээ нь ихэнх оронд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хуулийн орчны хүрээнд энэ мэдээллийг СББМҮҮБ олгох үүрэг хүлээдэг тул хүлээн авсан мэдээллээ баталгаатай, хараат бус баримт бичгээр дамжуулан баталгаажуулах зэргээр харилцагчдаа таньж мэдэхийг СББМҮҮБ-с шаарддаг. Ийм урьдчилсан нөхцөлүүдийг холбогдох ЭӨ-н мэдээллийг мэдээлэх дэглэмд оруулах замаар мэдүүлэг гаргагч этгээдээр бүртгэлд бүртгүүлэхийн өмнө мэдээлэлд зохих ЭӨ-н шалгалтыг хийлгэж үнэ зөвийг нь баталгаажуулуулдаг байх ёстой. Хэрэв гуравдагч тал судалгаа шалгалтаа зөрчин ЭӨ-н мэдээллийн үүргээ зөрчсөн байвал (жишээ нь үнэн зөв биш, хуурамч, буруу мэдээлэл өгсөн бол) санкц тавих ёстой. Бүртгэлд хуурамч, буруу мэдээллийг оруулахад санаатайгаар эсвэл хайхрамжгүй байдлаар дэмжлэг үзүүлсэн бол мөн санкц тавина.



Нүд 4: Словакт дахь гуравдагч талын хариуцлага⁶⁴

Словакт ЭӨ-н мэдээллийг Төрийн Түншлэлийн Бүртгэлд хуульч, нотариатч, аудитор, татварын зөвлөх зэрэг эрх бүхий этгээдийг бүртгүүлэхийг шаарддаг. Төрийн Түншлэгчийн Бүртгэлийн Хуулийн 5(б) Хэсэгт эрх бүхий этгээдийг ЭӨ-н мэдээллийг бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргахдаа үнэн зөв, бүрэн мэдээлэл өгөхийг үүрэг болгодог. Тус хуульд эрх бүхий этгээдийг ЭӨ-н мэдээлэлд аливаа өөрчлөлт орсоноос хойш 60 хоногийн дотор бүртгэлд мэдэгдэн ЭӨ-н мэдээллийг шинэчлэн баталгаажуулах баримт бичгийг өгөхийг үүрэг болгодог (Хэсэг 9). Хуулийн Хэсэг 11(1)-т дараахыг тодорхой заасан байдаг:

*... төрийн түншлэгч болон эрх бүхий этгээд нь бүртгэлд оруулсан мэдээллийн үнэн зөв, эцсийн өмчлөгчдийн тодорхойлох мэдээлэл, эцсийн өмчлөгчийн тодорхойлох мэдээллийн баталгаажуулалт зэргийг хариуцна.*⁶⁵

Төрийн Түншлэгчийн Бүртгэлийн Хуулийн 13 Хэсэгт эрх бүхий этгээд нь мэргэжлийн анхаарал болгоомжийн дагуу үйлдсэн эсэхээ баталж чадахгүй бол бүртгэлд оруулсан хуурамч эсвэл дутуу ЭӨ-н мэдээлэлд хуулийн этгээдэд ноогдуулсан торгуулийг төлнө гэж заасан байдаг. Мөн эрх бүхий этгээд нь тухайн хуулийн этгээдэд ноогдуулсан санхүүгийн торгуулийн үйл ажиллагаанд оролцоно.

Нүд 5: Дани улс дахь гуравдагч талын үүрэг, хариуцлагын талаарх заалтууд⁶⁶

Дани улсад компани үүсгэн байгуулах үед бизнесийн бүртгэлээс хуульч, аудитор, банк зэрэг гуравдагч талуудыг шаардлагатай капиталыг бүрэн төлсөнийг баталгаажуулахыг шаарддаг. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг үүрэг хүлээх болон харилцагчийг судлан шалгах ёстой талууд нь компанийг үүсгэн байгуулах ажиллагаанд ихэнхдээ оролцдог гэсэн үг юм.

Бизнесийн Төв Бүртгэлд хуулийн этгээдүүдийг үүсгэж эсвэл байлгаж буй хувь хүн, байгууллага нь тусгай таниулах үнэмлэх (NemID) ашиглах ёстой ба Бизнесийн Төв Бүртгэлд орсон мэдээлэл үнэн зөв болох дээр цахимаар гарын үсэг зурах ёстой байдаг. NemID-г төрийн агентлагаас олгодог ба энэ нь Данийн Бизнесийн Ерөнхий Газар баталгаажуулалт хийх зорилгоор ашиглаж болох бүртгүүлж байгаа этгээдийн талаарх дижитал мэдээлэл бүхий цахим мөр үлдээдэг. NemID-г мөн төрийн байгууллага болон интернет банкнаас мэдээлэл авах зэрэг бусад зорилгоор интернетэд аюулгүй нэвтрэхэд ашигладаг.



Компаний алба хаагч

Компаний алба хаагчаар бүртгэлд хангалттай, үнэн зөв, сүүлийн үеийн ЭӨ-н мэдээллийг оруулах шаардлагатай алхамуудыг авахуулахын тулд компаний албан хаагчдыг ЭӨ-н санкцын дэглэмд оруулах нь чухал юм. Энэ тал дээр компаний алба хаагч гэж хэнийг хэлэх вэ гэсэн асуулт гарч ирнэ. Үүнд ихэвчлэн компаний захирлууд,^f удирдах ажилтнууд, удирдлагууд орно. Жишээ нь Дани улсад аливаа компани ЭӨ-н мэдээллээ бүртгүүлээгүй эсвэл эрх бүхий байгууллагад өгөөгүй бол тухайн компани болон удирдлагыг эрүүгийн хэрэг үйлдсэнд тооцдог.⁶⁷ Францад компаний менежер ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг мөрдөөгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх (зургаан сар хоригдон 7,500 евро буюу ойролцоогоор 8,200 ам.доллараар торгуулах) эсвэл компаний удирдлагад ажиллуулахгүй байх гэсэн ойролцоо заалт байдаг.⁶⁸

Белгид ЭӨ-н мэдээлэл өгөх шаардлагыг мөрдөөгүй компанийн захирлыг эрүүгийн хэргээр 50-иас 5,000 еврогоор торгох (ойролцоогоор 55-5,500 ам.доллар), захирал, зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх комисс, удирдлагад оролцогч этгээд зэрэг зөрчил үйлдсэн этгээдүүдийг захиргааны шийтгэлийн хүрээнд 250-иас 50,000 еврогоор (ойролцоогоор 275-60,300 ам.доллар) торгодог.⁶⁹ Санкцын цогц дэглэмийн хүрээнд улс орнууд компаний алба хаагчдад санкц ноогдуулах талаар бодолцож үзэх ёстой.

Хуулийн этгээд

Дийлэнх улс оронд ЭӨ-н мэдээллийг мэдээлэх дэглэмийг зөрчвөл хуулийн этгээдэд хариуцлага, санкц тавина гэсэн хуулийн заалтууд байдаг. Гэхдээ эдгээр санкцууд нь ихэвчлэн эрүүгийн бус санхүүгийн болон санхүүгийн бус санкцууд байдаг.

Компанид эрүүгийн хэрэг үүсгэх нь дийлэнх оронд байдаггүй зүйл ба ийм санкцыг хэрэгжүүлэх нь тухайн орны эрх зүйн системээс шалтгаалдаг ба орон оронд өөр байдаг. Жишээ нь Англи, АНУ-д голчлон авлига, мөнгө угаасан хэрэгт компанид эрүүгийн хэрэг үүсгэдэг. Англид эцсийн өмчлөгчдийн талаар худал мэдээлэл өгвөл компанид эрүүгийн хэрэг үүсгэнэ. Шийтгэл нь хоёр жил хорих (дээр дурдсанчлан захирлуудад эрүүгийн хариуцлага ноогдуулсанаар) Үүнтэй ойролцоо нь Английн Авлигын Хууль 2010-н 7-р Хэсэгт авлигаас урьдчилан сэргийлэх хангалттай арга хэмжээ аваагүй компанид хэрэг үүсгэнэ.

Гэхдээ хуулийн этгээд зэрэг амьгүй үйлдэгч нь санаа зорилго агуулах боломжгүй тул хариуцлага хүлээж чадахгүй гэдгийг ихэд онцолдог иргэний эрх зүйт орнуудад ялангуяа компанид эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь үндсэн хуулийн хувьд зохистой юу эсэх нь ихээхэн маргаантай асуудал байдаг. Ямартай ч Белги, Дани, Франц, Голланд зэрэг зарим иргэний эрх зүйт орнуудад компанид эрүүгийн хариуцлага хүлээлгэх хууль журам баталсан байдаг нь үүнийг иргэний хуулийн үндсэн хуулийн дагалдагч биш гэдгийг тодорхой хэмжээнд харуулж байна. Гэхдээ дээр дурдсанчлан компанид эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь тухайн орны эрх зүйн системээс хамааран бүх оронд бүтэхгүй байж болно.

^f Англид сүүдэр захирлыг хүртэл компаний алба хаагч гэж үзэх ёстой гэж шаарддаг.



Санкцыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх

Энэ хэсэгт санкцыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бодлого гаргагч, хэрэгжүүлэгчдийн шинжлэн хариулах зарим гол асуулт, бодолцох зүйлсийг онцолж байна.

Санкц тавихын өмнөх өршөөлийн хугацаа, мөрдөлт

Бодлого гаргагчдын хувьд бодолцох ёстой эхний гол зүйл нь санкц тавихын өмнө хуулийн этгээдэд олгох (байвал) өршөөлийн хугацаа болон түүний үргэлжлэх хугацааг тогтоох асуудал юм. Санкц тавих, мөрдүүлэхийг тодорхой хугацаагаар хойшлуулах замаар хуулийн этгээдүүдэд ЭӨ-н мэдээллийг мэдээлэх, бүртгүүлэх шаардлагыг таниулах чиг хандлага олон оронд ажиллагдаж байна. Колумбад энэхүү анхдагч өршөөлийн хугацаа 8 сар⁷⁰ байсан ба АНУ нэг жил өгөх талаар бодолцож байна.⁷¹ Кени улс “журам мөрдөх боломжийг олгохын тулд” анхны хугацааг сунгасан.⁷² Хуулийн этгээдүүд энэ хугацаанд хүчтэй торгуулахгүй гэдгээ мэдэж байгаа тул эдгээр хугацааг буруугаар ашиглах боломж бий. Иймд эдгээр хугацааг хувийн хэвшилтэй зөвлөлдөн боломжийн хэрээр богино байлгах хэрэгтэй юм; үүнийг эрсдэлд суурилсан аргыг ашиглан тогтоож болно.

Санкцын түвшин, төрөл

Санкцыг урьдчилан сэргийлэх чанартай болгохын тулд бодлого гаргагч, хэрэгжүүлэгчдийн бодолцох эхний зүйл бол санхүүгийн санкцын хэмжээг хувь хүн, байгууллагын хувьд хэт доор тавьж ЭӨ-н мэдээллийг өгөхийн оронд торгууль төлөх боломжийг олгохгүй байх асуудал юм. Энэ түвшин нь орон орны хувьд өөр байх ба санкцын хэмжээ хэт бага байсан нэг л явган баримт бий. Жишээ нь Гана улсад ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг мөрдөөгүйгээс төлөх 350 ам.долларын торгууль нь шаардлагыг мөрдөхөөс хямд байсан тул компаниуд торгуулийг нь төлөх сонголтыг хийж байв.⁷³ Энэ нь мөн давтан үл мөрдөлтөд илүү хүнд санкц тавих хэрэгтэйг онцолж байна.

Мөнгө угаах болон Терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг арга хэмжээний Үнэлгээний Мэргэжлийн Комисс 2019 (MONEYVAL) болон Мальта улсын Хамтын үнэлгээний тайлангаар (MER) Мальтад явагддаг бизнесийн чиглэл, цар хүрээнд тулгуурлан ЭӨ-н мэдээллийг бүртгэлд өгөөгүй компани, түншлэл, холбоодод 500-1000 еврог (ойролцоогоор 550-1,100 ам.доллар) хоногийн 5-10 долларын (ойролцоогоор 5.50-11 ам.доллар) торгуулийн хамтаар торгох нь урьдчилан сэргийлэх, тэнцвэртэй байхад хэтэрхий бага дүн гэж тэмдэглэсэн байдаг. Эдгээр дутагдлуудыг шийдэхийн тулд Мальта улс торгуулиа арав дахин нэмж мөн санхүүгийн бус санкцуудыг нэвтрүүлжээ.⁷⁴ Энэ тохиолдолд улс орнууд илүү өндөр торгууль тавих; салбарын эрсдэлд үндэслэн өөр өөр салбарт өөр өөр торгууль тавих; эсвэл орлого, эргэлтийн хувь зэрэг хувьсах торгууль тавих талаар бодолцож үзэж болно; Гэхдээ сүүлийн хоёр аргыг одоогоор хэрэгжүүлсэн туршлага харагдахгүй байгаа ба энэ нь ийм торгуулийг бодит байдал дээр хэрэгжүүлэхэд учрах бэрхшээлүүдтэй холбоотой байх боломжтой юм. Гэхдээ “зөрчлөөс олж авсан эдийн засгийн давуу талын дүнг хоёр дахин хүртэл” хэмжээгээр торгох санкцыг Германд хэрэгжүүлсэн.⁷⁵

Санкцыг урьдчилан сэргийлэх чанартай болгохын тулд улс орнууд ЭӨ-н санкцын дэглэмээ зөвхөн санхүүгийн санкцаар хязгаарлаж болохгүй. Иргэн, хуулийн этгээд, байгууллагын эсрэг санхүүгийн санкц болон эрүүгийн санкц тавих заалтыг ЭӨ-н хууль тогтоомжид оруулах ёстой. Мөн санкцуудаа тогтмол эргэн хянаж шинэчлэн үр дүнтэй, урьдчилан сэргийлэхүйц, тэнцвэртэй байлгах нь улс орнуудын хувьд чухал юм.

Нийцлийн ерөнхий соёл зэрэг хувьсагч хүчин зүйлс маш олон байдаг тул санкцын үр дүнг хэмжих болон санкц, нийцэл хоёрын харилцан хамаарлын шууд шалтгаан нөлөөг тогтооход бэрхшээлтэй байдаг. Мэдээллийг их хэмжээгээр бүртгүүлж байгааг зөвхөн санкцтай холбож болохгүй ч, ФАТФ-н зүгээс үр дүнтэй санкцтай холбоотой гэж үзжээ.⁷⁶ Австри (мэдээлэл бүртгүүлэлт 93%, 2019 оны 7-р сарын байдлаар),⁷⁷ Дани (мэдээлэл бүртгүүлэлт 96%, 2019 оны 1-р сарын байдлаар),⁷⁸



Англи (мэдээлэл бүртгүүлэлт 99%, 2019 оны 3-р сарын байдлаар),⁷⁹ зэрэг мэдээллийг их хэмжээгээр бүртгүүлж байгаа орнууд ЭӨ-н санкцын дэглэмдээ санхүүгийн санцаас өөр санкцуудыг оруулсан байдаг.

Нүд 6: Дани улсын санхүүгийн бус санкцууд⁸⁰

Дани улсад ихэнхи хуулийн этгээдүүдийн хувьд Бизнесийн Төв Бүртгэлийн (БТБ) дугаар авахын тулд ЭӨ-н мэдээллийг бүртгүүлэх ёстой байдаг. Хэрэв тухайн этгээдүүд хангалттай мэдээллийг бүртгэлд бүртгүүлээгүй бол тухайн аж ахуйн нэгжийг албадан татан буулгах заалт хуульд байдаг. Компани болон түүний удирдлага нь ЭӨ-н мэдээллийг бүртгэлд өгөөгүй бол эрүүгийн зөрчилд тооцдог. Данид бүртгүүлэх шаардлагатай түншлэл болон хязгаарлагдмал түншлэлийг ЭӨ-н хангалттай мэдээллийг өгөөгүй эсвэл эцсийн өмчлөгчийг бүртгүүлээгүй бол БТБ-ээс хасч болно.

2018 оны 11-р сарын байдлаар Дани Улсын Бизнесийн Ерөнхий Газар (ДУБЕГ) ЭӨ-н мэдээллийг хугацаанд нь бүртгүүлээгүй гэсэн шалтгаанаар 7,500 компанийг татан буулгажээ. 2019 оны 1-р сарын байдлаар ЭӨ-н хуулийг мөрдөх ёстой байгууллагуудын ойролцоогоор 96% нь ЭӨ-н мэдээллээ бүртгүүлсэн байна. Цаашлаад ДУБЕГ-н хариуцдаг, компаний хуулийг мөрдөх ёстой байгууллагуудын 99.8% ЭӨ-н мэдээллээ бүртгүүлсэн байна.

Цөөн хэдэн оронд ЭӨ-н мэдээллийн бүртгүүлэлт илт сайн байгаа ч ЭӨ-н дэглэмийнх нь үр дүнтэй байдалд яг ямар хүчин зүйлс нөлөөлсөн гэдгийг тогтооход маш хэцүү юм. Австрийн мэдээлэл бүртгүүлэлт 93% байгаа нь дарамт багатай, ашиглахад хялбар мэдээлэл цуглуулах болон бүртгүүлэх механизм; дижитал мэдээлэх заавар; програм дотроо нөхцөл, алдааг илрүүлдэг функцтай байх; автоматжуулсан баталгаажуулалтын журам зэрэг янз бүрийн хүчин зүйлстэй холбоотой байж болно.⁸¹ Ямартай ч Австриг автоматжуулсан санкцуудаас гадна ЭӨ-н мэдээллийг өгөх шаардлагыг биелүүлээгүйд ноогдуулдаг торгуулийн хэмжээ нь мөрдөлтийг нэмэгдүүлсэн хүчин зүйлсийн нэг гэдэг нь илт харагдаж байна (Нүд 9-г үз).

Нүд 7: Австрийн санкцын дэглэм⁸²

Австрийн Эцсийн Өмчлөгчийн Бүртгэлийн Хуульд (ЭӨБХ) санаатайгаар буруу эсвэл дутуу мэдээлэл өгсөн эсвэл мэдээлэл өгөөгүй бол 200,000 евро (ойролцоогоор 220,000 ам.доллар) хүртэлх, хайхрамжгүйгээр бол 100,000 евро (ойролцоогоор 110,000 ам.доллар) хүртэлх торгуулийн санц тавина гэж заасан байдаг (15-р Зүйл Догол Мөр 1 ЭӨБХ). Үүнд дараах тохиолдлууд орно:

- эцсийн өмчлөгчдийг үнэн зөв мэдээлэхгүй байх;
- эцсийн өмчлөгчийг тодорхойлох боломжгүй тодорхойгүй мэдээлэл өгөх;
- жил бүр бүртгүүлэх үүргийг үл биелүүлэх;
- хуулийн этгээдийг үүсгэн байгуулахдаа заасан хугацаанд мэдээлэл өгөөгүй;
- мэдээлэл өгөх үүргээс чөлөөлөгдсөн тодорхой хуулийн этгээдүүдийг (жишээ нь Трастын байгууллага, трасти гэрээ болон бусад хяналтын харилцаа зэрэг) хяналтаар дамжуулан өөр хувь хүн эцсийн байдлаар өмчилдөг байх тохиолдолд тухайн хуулийн этгээд нь мэдээлэл өгөх үүргээс чөлөөлөгдөхгүй ба үүний дагуу эцсийн өмчлөгч хувь хүнийг хуулиар шаардсаны дагуу ЭӨ-н бүртгэлд бүртгүүлээгүйд тооцсон тохиолдолд;
- эцсийн өмчлөгчийн мэдээлэлд өөрчлөлт орсоньг мэдсэнээс хойш дөрвөн долоо хоногийн дотор мэдээлээгүй тохиолдолд.

Давтан мэдээлээгүй тохиолдолд ЭӨБХ-н 16-р Зүйлийн дагуу шахалт өгөх торгуулийг хоёр удаа ноогдуулна.

Эцсийн өмчлөгчдийн талаарх ЭӨ-н бүртгэлд бүртгүүлсэн мэдээлэл нь зөв боловч Нийцлийн Багцын⁹ хүрээнд сайн дураар мэдээлэл өгөх явцад дамжуулсан баримт бичгүүд нь хуурамч эсвэл хуурамч болгосон байсан тохиолдолд 75,000 евро (ойролцоогоор 8,200 ам.доллар) хүртэлх торгуулиар шийтгэнэ.

⁹ Нийцлийн Багц нь 2020 оны 11-р сарын 10-ны өдрийн байдлаар хуулийн этгээдүүдийн сайн дүрээр бүртгэлд мэдээлэх ЭӨ-г тодорхойлон баталгаажуулахад шаардагдах цогц баримт бичгүүд тул судалгаа хийх үүргээ биелүүлэх зорилгоор үүрэг хүлээсэн талууд хянан шалгаж ашиглаж болно. Нэмэлт мэдээллийг дараахаас авна уу: "Нийцлийн Багц", Сангийн Яам, Австри, n.d., <https://www.bmf.gv.at/en/topics/financial-sector/beneficial-owners-register-act/Compliance-Package.html>.



Мэдээлэл өгөхдөө албан ёсны зураг бүхий үнэмлэхийн хуулбар өгөөгүй эсвэл тухайн эцсийн өмчлөгчийн мэдээлэл буруу, дутуу байвал 25,000 евро (ойролцоогоор 27,500 ам.доллар) хүртэлх торгуулиар шийтгэнэ.

Хуулийн этгээд нь зөв мэдээлэл өгөх санаатай байсан ч Нийцлийн Багцын хүрээнд сайн дураар мэдээлэх үедээ нэгж баримт бичгүүдийг дамжуулаагүй эсвэл бусад үүргийг хангаагүй тохиолдолд өөр санкц ноогдуулаагүй тухайн хуулийн этгээдийг 10,000 евро (ойролцоогоор 11,000 ам.доллар) хүртэлх торгуулиар шийтгэнэ.

Эцсийн өмчлөгчийн бус санкцын дэглэм дэх холбогдох сайн туршлагауд

Тухайн орон нь байгууллагаас жилийн татварын тайлан, санхүүгийн тайлан хүлээн авах зэрэг ЭӨ-н мэдээллийг бүртгүүлэхтэй ойролцоо өөр чиглэлд үр дүнтэй санкцын дэглэм хэрэгжүүлдэг байж болно. Бодлого гаргагч, хэрэгжүүлэгчид нь санкц, мөрдүүлэлтийг ойролцоо дэглэмээр хэрхэн хэрэгжүүлж байсан, үүнээс өөрсдийн ЭӨИТБ-н дэглэмд ямар сайн туршлагыг авч хэрэгжүүлж болох талаар бодолцож үзэх ёстой.

Жишээ нь Хонг Конгод Компаний Захирамжид мэдээлэл өгөх үүргийг биелүүлээгүй буюу бүртгэлд мэдээлэл оруулаагүй, жилийн орлогоо мэдүүлээгүй компаниудад санкц тавина гэж заасан байдаг. Хэрэв компани нь заасан хугацаанд биелүүлэхгүй бол тухайн компани болон компаний хариуцлага хүлээх этгээд бүрийг зөрчил гаргасанд тооцон 50,000 Хонг конг долларын (ойролцоогоор 6,400 ам.доллар) хариуцлага хүлээлгэнэ гэж Компаний Захирамжид заасан байдаг. Зөрчил үргэлжилсээр байвал үргэлжлэх хоног бүрт 1,000 Хонг конг долларын (ойролцоогоор 130 ам.доллар) торгууль төлнө.⁸³ Компаний Бүртгэгч нь жил дарааллан жилийн орлогоо мэдүүлээгүй компанийг бизнесийн үйл ажиллагаа явуулаагүйд тооцон бүртгэлээс хасах эрхтэй байна.⁸⁴ Мөн Хонг Конгод Компаний Захирамж (Нэмэлт өөрчлөлт) 2018-аар компаниудыг ЭӨ-н бүртгэлээ өөрсдөө авч хөтөлж байхыг шаарджээ. Энэхүү Захирамжид мөн хуурамч мэдээлэл олгох зэрэг тодорхой үйлдэлд тавих санкцуудыг заасан байна. Иймэрхүү хууль нь бодлого гаргагч, хэрэгжүүлэгчдэд ЭӨ-н төвлөрсөн бүртгэлд зориулсан үр дүнтэй санкцын дэглэмийг боловсруулах сургамжууд болно.

Эрх бүхий байгууллагуудын эрх үүргүүд

ЭӨ-н бүртгэлийг аль байгууллага, агентлаг хөтөлж хянах эсэх дээр улс орнуудын дунд нэгдсэн арга байдаггүй. Зарим оронд татварын байгууллага (Бразил) эсвэл төв банк (Коста Рика, Уругвай) хариуцдаг боловч компани бүртгэдэг учраас ЭӨ-н бүртгэлийг хөтлөхөд хамгийн тохиромжтой байгууллага болох компаний бүртгэл (Австри, Дани, Англи, Замби) ихэвчлэн хариуцдаг. Гэхдээ бүртгэгчийн хувьд олгосон мэдээллийг баталгаажуулах чадвар нь үнэн биш, бүрэн биш, хуурамч мэдээлэл авсан тохиолдолд санкц тавих хуулийн эрхтэй эсэхээс шалтгаална.⁸⁵ Журам биелүүлэгүй тохиолдолд ихэнхи бүртгэгчид тодорхой нэг төрлийн захиргааны шийтгэл ноогдуулж чадах ч бүртгэлийг түтгэлзүүлэх эсвэл цуцлахаас илүү гардаггүй.⁸⁶ Журам биелүүлээгүй тохиолдолд холбогдох прокурорын байгууллагад мэдэгддэг ч мөрдөн шалгалт хийх, хууль сахиулах чиг үүрэг тэдэнд байдаггүй.

Хэрэв журам мөрдүүлэх чиг үүргийг холбогдох өөр агентлаг биш бүртгэгч хариуцах бол бүртгэгчийн эрхийг бүртгэл хөтлөх гэхээсээ хянах байгууллагууруу чиглүүнэ. Иймд бодлого гаргагч, хэрэгжүүлэгч нар ЭӨ-н дэглэмийг зөрчсөн тохиолдолд санкц тавих эрхийг компани бүртгэгч болон бусад хариуцах байгууллагуудад өгөх замаар шаардлагатай эрх зүй, бодлогын шинэчлэлийг хийх ёстой. Үүнд шаардлагатай болон зохистой, хэрэгжүүлэх боломжтой мөрдөн шалгах болон журам мөрдүүлэх эрхүүдийг тогтоох орно. Энэ нь ЭӨ-н бүртгэгчид ялангуяа ач холбогдолтой бөгөөд үүнийг компани бүртгэгч зэрэг хууль сахиулах бус байгууллагад хариуцуулах хэрэгтэй. Үүнд жишээлбэл мэдээлэлд дүн шинжилгээ хийх; хуулийн этгээд, (эцсийн өмчлөгч, мэдэгдэл гаргагч этгээд, компаний алба хаагч зэрэг) холбогдох хувь хүн, бусад эрх бүхий байгууллагаас мэдээлэл, баримт бичиг шаардах, тэдэнд анхааруулга өгөх эрх; хувь хүн, хуулийн этгээд журам мөрдөөгүй тохиолдолд санкц тавих эрх (Австри) зэрэг орно.

Жишээ нь Англид ЭӨ-н бүртгэл хөтөлтийг Компаний Хэлтэс хариуцдаг боловч бүртгэлд өгсөн ЭӨ-н мэдээллийн үнэн зөв, хангалттай эсэхийг шалгах эрхгүй ба ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг зөрчсөн тохиолдолд санкц тавих хуулийн эрхгүй байдаг. Энэ нь Английн мэдээлэл найдвартай юу гэсэн асуулт тавигдахад хүргэсэн. Энэ цоорхойг нөхөхийн тулд бүртгэгчийн эрхийг сайжруулах тал дээр илүү өргөн шинэчлэлүүдийг санал болгосон.⁸⁷

Зориулалтын агентлаг болон бусад хууль сахиулах байгууллагуудын (жишээ нь эрүүгийн санкцыг мөрдүүлэх прокурор) хоорондын хамтын ажиллагаа,



уялдааг үр дүнтэй болгохын тулд журам мөрдүүлэх үүрэгтэй агентлагуудын хоорондох мэдээллийн солилцоог үр дүнтэй байлгах зохих журам, процессуудыг тавих хэрэгтэй. Жишээ нь ямар санкцуудыг хэн тавих эрхтэй байх вэ, төрийн аль байгууллага давж заалдахыг хариуцах гэдэг нь тодорхой байх ёстой; үүнийг ажилдаа дарагдсан шүүхийн системд хариуцуулж болохгүй ба учир нь сунжирсан процедур нь цоорхой үүсгэх боломжтой юм.

Гадны байгууллагад өгөх үр дүнтэй санкцууд

Тухайн компаний бүртгэгдсэн алба хаагч нь хилийн чанадад байдаг эсвэл аж ахуйн нэгжийн захирлууд өөрсдөө өөр байгууллага бол гадны байгууллагад санкц тавих нь улс орнуудын хувьд томоохон бэрхшээл болдог.⁸⁸

Гадаадын байгууллагуудын эсрэг хэрэгжүүлэх ЭӨИТБ-н санкцын дэглэмийг үр дүнтэй болгоё гэвэл санкцыг мэдээлэл олгож буй этгээдэд тавих боломжтой байх ёстой буюу бүртгэгч эсвэл бусад журам мөрдүүлэх байгууллага нь тухайн этгээдэд хууль мөрдүүлэх эрхтэй байх ёстой. Дээд дурдсанчлан үр дүнтэй механизм гэдэг нь эрх бүхий хувь хүн эсвэл СББМҮҮБ-г гадаадын байгууллагын өмнөөс ЭӨ-н мэдээллийг өгөх хариуцлага хүлээлгэх, тухайн мэдээллийн үнэн зөвийг хариуцуулах, мөн тухайн хууль хэрэгжих оронд оршин суугч байхыг шаардахыг хэлнэ. Санкцууд нь ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг зөрчсөн тохиолдолд тухайн хуулийн этгээдийг оруулаад холбогдох бүх талуудыг хамрах ёстой.

Санкцын талаарх мэдээлэл бүртгэх, тайлагнах, нийтлэх

ФАТФ-н 33-р зөвлөмж нь улс орнуудаас “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг системийн үр дүнтэй, үр ашигтай байдалтай холбоотой асуудлууд дээр цогц статистик хөтлөхийг” шаарддаг.⁸⁹ Энэхүү зөвлөмжтэй уялдуулан бодлого гаргагч, хэрэгжүүлэгч нарын бодолцож үзэх ёстой бас нэг чухал зүйл нь ЭӨ-н мэдээллийг мэдээлэх дэглэмийн хүрээнд хувь хүн, хуулийн этгээдэд тавих аливаа санкцуудын мэдээллийг хэрхэн бүртгэж хадгалах болон энэ мэдээллийг хэр ойр ойрхон шинэчлэх вэ гэдгийг тогтоох юм. Үүнээс гадна хэрэгжүүлэгчид нь энэхүү мэдээллийг хэзээ, хэрхэн холбогдох байгууллагуудад өгөх, мөн энэ мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох уу эсэхийг тогтоох ёстой.

Санкц болон ЭӨ-н шаардлагыг үл биелүүлсэн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй болгосноор журмыг илүү мөрдүүлэх ба бүртгэл дээрх ЭӨ-н мэдээллийн

үнэн зөв, бүрэн бүтэн, сүүлийн үеийн байдлыг хангах боломжтой болно. Гэвч хатуу санкц, мөрдүүлэлтийг бий болгоогүй цагт хэн нэгнийг буруутгах, зарлах нь үр дүнтэй биш байх магадлалтай. Жишээ нь хөдөлмөрийн зах зээлийн туршлага,⁹⁰ Англи дахь бизнесийн төлбөрийг сайжруулах практик,⁹¹ Нигер дахь үнэлгээ удирдлагын салбараас⁹² харахад компаниудыг зарлах, буруутгах арга нь дангаараа үр дүн өгдөггүй ажээ.

Санкцын мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох аргыг хэрэгжүүлсэн зарим оронд Белги, Герман, Польш орно. Байгууллагуудын ЭӨ-н мэдээллийг мэдээлэх дэглэмийн мөрдөлтийг идэвхжүүлэхийн тулд хэрэгжүүлэгчид санкц, мөрдүүлэлтийн (торгууль, хар жагсаалтад орсон зэрэг) мэдээллийг тухайн санкцыг ноогдуулсан огнооноос хойшхи богино, тодорхой заасан хугацаанд (14 хоног г.м.) олон нийтэд мэдээлэх талаар бодолцож үзэх хэрэгтэй.

Нүд 8: Санкц, мөрдүүлэлтийн мэдээллийг олон нийтэд мэдээлсэн орнуудын жишээ

Германд, мэдээлэл өгөх шаардлагаа биелүүлээгүй компаниудад тавьсан санкц бүрийг Ил тод байдлын бүртгэлийн вебсайт дээр тавихыг хуулиар шаарддаг.⁹³

Белгид, сангийн яам нь журам мөрдөөгүй хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдүүдийн хар жагсаалтыг дунд, урт хугацаанд нийтлэх механизмуудын нэг гэж тодорхойлсон боловч хараахан хэрэгжүүлээгүй байна.⁹⁴

Польш улсад, Худалдааны Бүртгэлийн Албаны хөтөлдөг нийтийн бүртгэлд ЭӨ-н төвлөрсөн бүртгэлд ЭӨ-н мэдээллийг өгөх үүргээ биелүүлээгүй аливаа аж ахуйн нэгжийг тодорхой зааж өгнө гэж хууль заасан байдаг.⁹⁵

Англид, Компаний Хэлтэс нь мэдээллийг хоцрогдуулж өгсөн тохиолдолд тавьсан торгууль, давж заалдсан талаарх мэдээлэл; Компаний Хууль 2006-н дагуу хэлтсээс хянан шийдвэрлэсэн хэргүүд; компаний хуулийг давтан зөрчсөнөөс үүдэн захирлуудын эрхийг хүчингүй болгосон мэдээллийг удирдлагын мэдээллийн статистикийн хүрээнд нийтэлдэг.⁹⁶ Гэхдээ мэдээллийг статистик гэж нийтэлдэггүй ба компаниудыг нэрлэдэггүй.



Мөрдүүлэлтийг хэрэгжүүлэх

Энэхүү танилцуулгад ЭӨ-тэй холбоотой зөрчлүүдэд тавих санкцуудыг мөрдүүлэх нь хэрэгжүүлэгчдийн хувьд яагаад бэрхшээлтэй байх талаарх олон шалтгааныг ерөнхий танилцуулсан. Санкцын дэглэмийг бодитоор ашиглаж байж л бодитой гэж үзнэ. ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг зөрчсөн этгээдүүдэд санкцыг тогтмол тавих ёстой. Санкцыг улс орнууд хүчтэй мөрдүүлэх хэрэгтэй.

Иймд бодлого гаргагч, хэрэгжүүлэгч нарын хувьд санкцыг үр дүнтэйгээр мөрдүүлэх боломжтой байдлаар хэрэгжүүлэхийг бодолцож үзэх нь чухал юм.

Санкцуудыг автоматжуулах

Бодлого гаргагч, хэрэгжүүлэгч нар боломжтой бол санкцыг автоматжуулах эсэхийг бодолцож үзэх хэрэгтэй. Зөрчлийг тогтоож автоматжуулсан шийтгэл ноогдуулах системийг боловсруулж болно. Жишээлбэл Австри, Белгид хуулийн этгээдүүдээс ЭӨ-н мэдээллийг сүүлийн үеийн, үнэн зөв, хангалттай эсэхийг жил бүр тодорхой заасан хугацаанд баталгаажуулж байхыг шаарддаг. Хэрэв энэ шаардлагыг хуулийн этгээдүүд заасан хугацаанд биелүүлэхгүй бол шахалт өгөх торгуулийг автоматаар өгнө. Австрийн хэрэгжүүлсэн автомат санкцын систем нь 2019 оны 7-р сарын байдлаар тус орны мэдээлэл бүртгүүлэлтийг 93%-д хүргэхэд хувь нэмэр болсон гэж ФАТФ-с хүлээн зөвшөөрчээ.⁹⁷

Нүд 9: Австрийн автомат санкцын систем⁹⁸

Австри улсад ЭӨ-н мэдээллийг мэдээлэх үүргийг тасралтгүй мөрдүүлэхийн тулд автомат шахалт өгөх торгуулийг хэрэгжүүлдэг. Шинээр байгуулагдсан байгууллагуудын хувьд 28 хоногийн дотор эсвэл анх мэдээлэх хугацаанд мэдээлээ өгөхгүй бол тухайн хуулийн этгээдэд 1,000 еврогийн (ойролцоогоор 1,100 ам.доллар) шахалт өгөх торгууль тавина гэсэн анхааруулга захидлыг эрх бүхий байгууллагаас автоматаар илгээдэг. Тухайн хуулийн этгээд нь анхааруулгад заасан хугацаанд мэдээлээ өгөөгүй тохиолдолд тухайн торгуулийг тавих ба 4,000 еврогийн (ойролцоогоор 4,400 ам.доллар) торгууль нэмж тавих анхааруулгыг өгдөг. Хэрэв тухайн хуулийн этгээд нь мэдээлээ өгөхгүй байсаар байвал 4,000 еврогийн шахалт өгөх торгууль тавьж хэргийг санхүүгийн шийтгэлийн албаруу шилжүүлдэг.

Үүнтэй ойролцоогоор ЭӨ-н мэдээллийг төрийн бусад мэдээллийн эх сурвалжтай харьцуулан баталгаажуулалт хийдэг зарим оронд шалгалтаар ЭӨ-н мэдэгдлийн аливаа мэдээллийг ЭӨ-н бүртгэл дээр заасан хугацаанд шинэчлээгүй байгаа нь илэрвэл автомат санкц тавигдаж болно. Автомат санкц нь мөрдүүлэлтийг хангахад шаардлагатай зардлыг бууруулах боломжтой Гэхдээ автомат санкцын системийг болгоомжтой боловсруулахгүй бол санкц их тавигдсанаар давж заалдалт ихээр нэмэгдвэл (шүүхийн зэрэг) өөр газрын ачааллыг нэмэгдүүлж болно.

Баталгаажуулалтын хүчирхэг шалгалт

ЭӨ-н мэдээллийг баталгаажуулах нь зөрчлийг тогтооход тус болох тул хуурамч мэдээлэл өгсөн тохиолдолд санкцыг мөрдүүлэх урьдчилсан нөхцөл болно. Тухайн орноос шалтгаалан баталгаажуулалтын өөр өөр механизмуудыг хэрэгжүүлж болно.⁹⁹ Жишээлбэл улс төрд нөлөө бүхий этгээдүүдийн хөрөнгө мэдэгдэх



бүртгэл болон татварын бүртгэл зэрэг төрийн бусад бүртгэл, мэдээллийн сантай харьцуулан шалгах нь өгсөн мэдээллийг баталгаажуулах хэрэг болж болно. Мөн үүрэг хүлээсэн байгууллагуудаас мэдээллийн зөрүүг мэдэгдэх шаардлага тавих зэргээр хуулийн орчинд баталгаажуулах өөр механизмыг оруулж болно.

Бүртгэл дээрх ЭӨ-н мэдээлэл болон өөр талд байгаа ЭӨ-н мэдээллийн хооронд зөрөөтэй зүйл буюу ялангуяа тухайн мэдээлэл нь үнэн зөв биш, хуурамч гэдэг нь тогтоогдвол эсвэл мэдээлэгдвэл холбогдох санкц, мөрдүүлэлтийн дэглэмд хэрэгжүүлэх зохих процедур байх ёстой. Энэ нь тухайн зөрөөтэй зүйлийг автомат систем, мэдэгдэх байгууллага, эрх бүхий байгууллага, иргэний нийгэм мэдэгдсэн эсэхээс үл хамааран хэрэгжүүлдэг байх ёстой. Аливаа санкц тавихын өмнө холбогдох байгууллага зохих процедурыг мөрддөг байх ёстой. Үүнд жишээ нь хуулийн этгээд, мэдэгдэл гаргагч этгээд, эцсийн өмчлөгчөөс (байгаа бол) тухайн мэдэгдсэн зөрүүтэй зүйлийг баталгаажуулах нэмэлт мэдээлэл эсвэл баримт бичгийг олгохыг шаардах, (татварын байгууллага зэрэг) бусад эрх бүхий байгууллагуудаас нэмэлт мэдээлэл цуглуулах зэрэг орно. Хэрэв дээрхийг хийснээр хангалттай шийдэлд хүрээгүй бол санкц тавих процедурыг мөрдөх ёстой.

Мөрдөн шалгах ажиллагаанд хангалтай чадамж, нөөц, хуулийн эрхийг олгох

Аж ахуйн нэгж журам мөрдөөгүй тохиолдолд болон тухайн аж ахуйн нэгжээс шаардсан мэдээллийг хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч нар олголгүй журам мөрдөөгүй тохиолдолд санкц тавих чадамжтай байж мөрдүүлэлт үр дүнтэй болно. Мөрдүүлэлтийг үр дүнтэй хийдэг гэсэн бодит туршлага, баримт байх нь тухайн оронд урьдчилан сэргийлэх нөлөөллийг нэмэгдүүлэх магадлалтай юм.¹⁰⁰

Энэ тал дээр хэрэгжүүлэгчид дараах зүйлсийг хангах ёстой:

1. ЭӨ-н мэдээллийг мэдээлэх дэглэмийн зөрчил гарсан тохиолдолд мөрдөн шалгах, мөрдүүлэх эрх бүхий байгууллага эрх зүйн тодорхой эрхтэй байх;¹⁰¹
2. тухайн байгууллага, агентлагууд чиг үүргээ үр дүнтэйгээр гүйцэтгэхэд (хүн, техникийн) хангалттай чадамж нөөцтэй байх.

Хангалттай чадамж нөөцгүй байхыг ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагыг мөрдүүлэхэд тулгардаг том саадуудын нэг гэж үзэх хандлага олон байдаг. Жишээлбэл Белги улсад нөөцийн хязгаарлагдмал байдал, тухайн ажлын цар хүрээнд шалтгаалан эрх бүхий байгууллага

нь хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдүүдийн бүртгүүлсэн мэдээлэлд системтэй урьдчилсан хяналт тавих боломжгүй байдаг гэсэн мэдээ бий.¹⁰² Англид мөн ойролцоо нөөцийн хязгаарлалт байдаг тухай мэдээ бий.¹⁰³

Нотлох үүрэг

Бодлого гаргагч, хэрэгжүүлэгчдийн бодолцож үзэх ёстой бас нэг чухал зүйл нь тухайн хувь хүн, хуулийн этгээд нь ЭӨ-н мэдээллийг мэдээлэх дэглэмийн шаардлагыг зөрчсөн, үгүйг нотлох үүрэг хэнд ноогдох ёстой тогтоох юм. Үүнийг мөрдөн шалгагчид, мөрдүүлэх байгууллага эсвэл хувь хүн эсвэл хуулийн этгээдэд ноогдуулж болно. Ахин хэлэхэд энэ нь тухайн орны эрх зүйн системээс хамааран өөр өөр байж болно. Захиргааны болон иргэний торгууль санкцын хувьд нотлох үүргийг хувь хүн, хуулийн этгээдэд ноогдуулсанаар бүртгэлд өгсөн ЭӨ-н мэдээллийн чанар, үнэн зөв байдлыг ихээр сайжруулах боломжтой. Энэ арга ажиллагааг Словакт хэрэгжүүлдэг. Иргэн эсвэл хуулийн этгээд нь бүртгэлд үнэн зөв, бүрэн, сүүлийн үеийн мэдээллийг анхнаасаа бүртгүүлсэн бол тухайн бүртгүүлсэн мэдээллийн үнэн зөвийг нотлох үүргийг мөрдөн шалгагчдад өгсөнөөс өөрсдөөр нь нотлуулах нь хүндрэл багатай байна. Учир нь ялангуяа баталгаажуулалтын механизм хязгаарлагдмал байдаг орнуудын хувьд мөрдөн шалгах ажиллагаа нь цаг, зардал ихтэй байж болох юм. Оршин суугч биш хуулийн этгээд болон оршин суугч биш эцсийн өмчлөгчөөс авсан мэдээлэл зэрэг баталгаажуулахад хэцүү бусад мэдэгдлүүдийн хувьд энэ аргыг ашиглах нь үр дүнтэй байж болно.

Нүд 10: Словакийн өөрөө нотлох үүрэг¹⁰⁴

Словак улсад хэн нэгний мэдээлэл шалгуулах хүсэлтийг Бүртгэлийн Шүүхээс үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд Бүртгэлийн Шүүхийн хөтөлдөг Төрийн Түншлэлийн Бүртгэлд өгсөн мэдээллийг баталгаажуулахыг компаниас шаарддаг ажиллагаа байдаг. Энэ нь хоёр зарчимд үндэслэн өөрөө нотлох үүргийг үүсгэдэг:

1. мэдээлэл бүртгүүлсэн этгээдүүд нь тухайн мэдээллийг хамгийн сайн мэддэг тул тэднээр нотлуулах нь зөв зохистой юм;
2. өмчлөгч нь тухайн өмчлөлөөс хамгийн их ашиг хүртдэг учраас өмчлөгчид үүрэг болгох нь шударга юм.



Дүгнэлт

Хангалттай, үнэн зөв, сүүлийн үеийн ЭӨ-н мэдээллийг агуулсан ЭӨ-н мэдээллийн дэглэмийг үр дүнтэй байлгахын тулд улс орнуудын хувьд үр дүнтэй, тэнцвэртэй, урьдчилан сэргийлэх санкцуудыг хэрэгжүүлж мөрдүүлэх нь маш чухал юм. Энэ бодлогын танилцуулга нь НӨ-н зарчмын хамтаар ЭӨ-н санкцын дэглэмийг хэрхэн сайн боловсруулж мөрдүүлэх талаар бодолцох асуудлын хүрээ олгоно.

Товчхондоо энэхүү бодлогын танилцуулга нь үр дүнтэй, урьдчилан сэргийлэх, тэнцвэртэй санкц болон мөрдүүлэх дэглэмийг бий болгон ЭӨ-н мэдээллийг мэдээлэх шаардлагын мөрдөлтийг нэмэгдүүлж мэдээллийг хангалттай, үнэн зөв, сүүлийн үеийн байлгах талаар бодлого гаргагч, хэрэгжүүлэгчдийн бодолцож үзэх ёстой гол зүйлсийг ерөнхий авч үзсэн болно. Санкцын дэглэм нь хувь хүн, хуулийн этгээд, хуулийн бүтэц бүхий байгууллагуудын эсрэг захиргаа, санхүү, санхүүгийн бус, эрүүгийн санкцуудын янз бүрийн хослолыг хэрэгжүүлэх ёстой. Зөвхөн мөнгөн торгууль тавих эсвэл хэт бага торгууль тавих нь санкцыг зүгээр бизнесийн үйл ажиллагаа явуулах зардал гэсэн ойлголт төрүүлэхэд хүргэж болно. Энэ танилцуулгад мөнгөн торгуулиас илүү үр дүнд хүргэж болох янз бүрийн санхүүгийн бус санкцуудыг авч хэлэлцсэн. Хариуцлагын цоорхой үүсгэхээс зайлсхийхийн тулд санкцууд нь мэдэгдэгч этгээд, эцсийн өмчлөгч, компаний алба хаагч зэрэг компаний бүх гол этгээдүүд болон тухайн компанийг хамрах ёстой. Ингэснээр урьдчилан сэргийлэх нөлөө нь мэдээлэл олгоход оролцдог бүх гол үйлдэгчдэд хамаарах боломжтой болно. Мөн аливаа улс орон нь ЭӨ-тэй холбоотой үүргийг (нотариатч, хуульч зэрэг) гуравдагч талд ноогдуулсан тохиолдолд эдгээр гуравдагч талуудад үүргээ биелүүлээгүй эсвэл зөрчсөн тохиолдолд санкц тавих ёстой. Оршин суугч бус ЭӨ болон компаниуд байгаа зэрэг зарим тохиолдолд хэрэгжүүлэгчид нь мэдэгдлийг оршин суугч гуравдагч талаар гаргуулж зөв болохыг нь баталгаажуулах замаар мэдэгдэлд оролцдог гол үйлдэгчдийг хуулийн үйлчлэлд оруулах талаар бодолцож үзэх ёстой. ЭӨ-н мэдээллийг өгөхгүй байх, хоцрогдуулах, дутуу өгөх, хуурамчаар өгөх зэрэг бүх төрлийн үл мөрдөлт болон давтан үл мөрдөлтөд санкц

тавих ёстой. Мөн ЭӨ-н мэдээллийг буруугаар ашиглах зэрэг ЭӨ-тэй холбоотой бусад зөрчилд санкц тавих эсэхийг хэрэгжүүлэгчид бодолцон үзэж болно.

Санкц болон мөрдүүлэлтийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхийн тулд санкцыг аль эрх бүхий байгууллага хариуцах вэ гэдгийг тодорхой тогтоож өгөх ёстой. Тухайн санкц тавих байгууллага нь мөрдөн шалгах, хууль сахиулах чиг үүргийг гүйцэтгэх зэрэг санкцыг мөрдүүлэх хангалттай нөөц, хуулийн эрхтэй байх ёстой юм. Санкц тавих байгууллага болон прокурор зэрэг мөрдүүлэлтийг хангах үүрэгтэй агентлагуудын хооронд мэдээллийг үр дүнтэй дамжуулах зохих процедур, процесс байх ёстой. Санкцын урьдчилан сэргийлэх нөлөөг нэмэгдүүлэхийн тулд тавьсан санкцын талаарх мэдээллийг нийтэлж болно. Боломжтой бол санкцуудыг автоматжуулах хэрэгтэй ба (хуурамч мэдээлэл өгөх зэрэг) үл мөрдөлтийг илрүүлэхийн тулд хүчирхэг баталгаажуулах шалгалт процесс байх шаардлагатай. Захиргаа болон иргэний торгууль санкц тавьсан тохиолдолд нотлох үүргийг мэдээлэл олгогч талд ноогдуулах нь мөрдүүлэх хүчирхэг хэрэгсэл байж болно.

Эцэст нь журам мөрдөх соёл зэрэг өөр олон хувьсагч байгаа үед санкц, мөрдөлт хоёрын хоорондох шууд хамаарлыг тодорхойлох нь бэрхшээлтэй тул санкцын үр дүнтэй байдлыг хэмжихэд хэцүү юм. Санкцын дэглэмийг хэрэгжүүлэх үүрэгтэй бодлого гаргагчид нь гаргасан санкц, хянан шийдвэрлэлтийн дүн болон журам мөрдөлт зэргийн статистик мэдээг цуглуулж, хянан, нийтэлсэнээр санкц, мөрдөлт хоёрын хоорондох хамаарал болон санкцыг юу үр дүнтэй, урьдчилан сэргийлэх шинж чанартай, тэнцвэртэй болгож байгааг бусдад илүү сайн ойлгуулах боломж бүрдэнэ.



Төгсгөлийн тэмдэглэл

- 1 Дараахын Зөвлөмж 24, 25-г үз: Мөнгө Угаах, Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Олон Улсын Стандарт, (Парис: ФАТФ, 2022 оны 3-р сард шинэчилсэн), 22, <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/pdfs/FATF%20Recommendations%202012.pdf>; Европын (ЕХ) Парламент болон Зөвлөлийн 2018 оны 5-р сарын 30-ны өдрийн Захирамж 2018/843, Санхүүгийн системийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор ашиглуулахаас урьдчилан сэргийлэх нэмэлт өөрчлөлт оруулсан Захирамж (ЕХ) 2015/849 (МУЭТЗ), Зүйл 30 ба 31, <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX:32018L0843&from=EN>.
- 2 МУ/ТСТ Системийн Үр дүн, ФАТФ-н Зөвлөмжийн Техникийн Нийцлийг Дүгнэх Аргачлал (Парис: ФАТФ, 2021 оны 10-р сард шинэчилсэн), 111, <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/methodology/FATF%20Methodology%2022%20Feb%202013.pdf>.
- 3 Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн Сайн Туршлага (Парис: ФАТФ, 2019 оны 10-р сар), 15, <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/Best-Practices-Beneficial-Ownership-Legal-Persons.pdf>.
- 4 Ibid, 66.
- 5 “Нээлттэй Өмчлөлийн Зарчмууд”, Нээлттэй Өмчлөл, 2021 оны 7-р сард шинэчилсэн, <https://www.openownership.org/en/principles/>.
- 6 “Нээлттэй Өмчлөлийн Зарчмууд – Санц ба мөрдүүлэлт”, Нээлттэй Өмчлөл, 2021 оны 7-р сард шинэчилсэн, <https://www.openownership.org/en/principles/sanctions-and-enforcement/>.
- 7 “Нээлттэй Өмчлөлийн Зарчмууд – Хүчирхэг тодорхойлолт”-г үзнэ үү, Нээлттэй Өмчлөл, 2021 оны 7-р сард шинэчилсэн, <https://www.openownership.org/en/principles/robust-definition/>.
- 8 “Нээлттэй Өмчлөлийн Зарчмууд – Цогц хамралт”-г үзнэ үү, Нээлттэй Өмчлөл, 2021 оны 7-р сард шинэчилсэн, <https://www.openownership.org/en/principles/comprehensive-coverage/>.
- 9 “Нээлттэй Өмчлөлийн Зарчмууд – Хангалттай мэдээлэл”-г үзнэ үү, Нээлттэй Өмчлөл, 2021 оны 7-р сард шинэчилсэн, <https://www.openownership.org/en/principles/sufficient-detail/>.
- 10 “Нээлттэй Өмчлөлийн Зарчмууд – Шинэчилсэн ба аудит хийх боломжтой”-г үзнэ үү, Нээлттэй Өмчлөл, 2021 оны 7-р сард шинэчилсэн, <https://www.openownership.org/en/principles/up-to-date-and-auditable/>.
- 11 “Нээлттэй Өмчлөлийн Зарчмууд – Баталгаажуулалт”-г үзнэ үү, Нээлттэй Өмчлөл, 2021 оны 7-р сард шинэчилсэн, <https://www.openownership.org/en/principles/verification/>.
- 12 “Peraturan Menteri Hukum Dan Hak Asasi Manusia, Republik Indonesia, Nomor 21 Tahun 2019”, Berita Negara Republik Indonesia, 2019, <https://peraturan.go.id/common/dokumen/bn/2019/BN%201112-2019.pdf>.
- 13 “Авлигаас Урьдчилан Сэргийлэх Арга хэмжээ: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, тусгай зөвшөөрөл олгох, Төрийн худалдан авалтад эцсийн өмчлөгчийн мэдээллийг ашиглах нь”, Komisi Pemberantasan Korupsi, Танилцуулга, 2021 оны 11-р сарын 30.
- 14 ST Corporation Staff, “Украин эцсийн өмчлөгчийн мэдээлэлтэй холбоотой шинэ удирдамж гаргалаа”, Wolters Kluwer, 2021 оны 8-р сарын 3, <https://www.wolterskluwer.com/en/expert-insights/ukraine-issues-new-guidance-on-beneficial-ownership-reporting>.
- 15 Мөнгө Угаах, Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Олон Улсын Стандарт, ФАТФ, 94.
- 16 Tymo Kiere, “эцсийн өмчлөгчийн Мэдээллийг Баталгаажуулах”, Нээлттэй Өмчлөл, 2020 оны 10-р сар, 10, <https://www.openownership.org/uploads/oo-briefing-verification-briefing-2020-05.pdf>.
- 17 G. A. Gegenheimer, эцсийн өмчлөгчийн үнэн зөв, шинэчилсэн мэдээллийг авах процесс, орчинг сайжруулах талаар Филлипинд өгөх Зөвлөмжийн Тайлан (Филлипин: ADB TA-9433 REG Enhancing Tax Transparency of ADB Developing Member Countries, April 2021), unpublished, 64.
- 18 “Хуурамч компаний мэдээлэл өгсөн хэрэгт ‘анх удаа’ Англид ял өглөө”, Компаний Хэлтэс, 2018 оны 3-р сарын 23, <https://www.gov.uk/government/news/uks-first-ever-successful-prosecution-for-false-company-information>.
- 19 Peter Stubley, “Companies House lambasted for trumpeting conviction of fraud whistleblower Kevin Brewer”, The Independent, 17 April 2018, <https://www.independent.co.uk/news/uk/home-news/companies-house-fraud-whistleblower-prosecuting-kevin-brewer-vince-cable-a8307246.html>.
- 20 Хуулийн этгээдүүдийн эцсийн өмчлөгчийн Сайн Туршлагууд, ФАТФ, 65.
- 21 Жишээ нь дараахыг үзнэ үү: “Нээлттэй Өмчлөлийн Зарчмууд – Нээлттэй хүртээмж”, Нээлттэй Өмчлөл, 2021 оны 7-р сард шинэчилсэн, <https://www.openownership.org/principles/public-access/>.
- 22 эцсийн өмчлөгчийн Бүртгэл: 2019 онд шинэчилсэн”, PricewaterhouseCoopers (PWC), 2019 оны 12-р сар, <https://www.pwc.nl/nl/assets/documents/the-ubo-register-update-december-2019.pdf>.
- 23 James A. Kopfensteiner and William E. Quick, “Компаний Ил Тод Байдлын Хууль: Аж ахуйн нэгжийн эцсийн өмчлөгчийн Мэдээллийг мэдэгдэх шаардлагатай боллоо”, The National Law Review, 2021 оны 3-р сарын 17, <https://www.natlawreview.com/article/corporate-transparency-act-your-beneficial-entity-ownership-disclosure-now-required>.
- 24 Татварын Асуудлаар Санхүүгийн Дансны Мэдээллийг Автоматаар Солилцох Стандарт Хоёр дахь хэвлэл (OECD Publishing: Парис, 2014 оны 7-р сарын 21), 82, <https://www.oecd.org/ctp/exchange-of-tax-information/standard-for-automatic-exchange-of-financial-account-information-for-tax-matters-9789264216525-en.htm>.
- 25 “Олборлох Үйлдвэрийн Ил Тод Байдлын Санаачилгыг хэрэгжүүлэгч орон дахь эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах эрх зүйн аргачлалууд”, EITI, 2019 оны 6-р сар, 15, <https://eiti.org/documents/legal-approaches-beneficial-ownership-transparency-eiti-countries>.
- 26 “эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах эрх зүйн аргачлалууд”, EITI.
- 27 Ibid.
- 28 Ibid.
- 29 Article 13.2(a) and (b), Law No. 112/2020, <https://qbz.gov.al/eli/fz/2020/149/4a837817-b94a-4218-a611-893fc37cec4e>.
- 30 Зүйл 99.1.34b, Мөнгө угаах, Терроризмыг Санхүүжүүлэхээс Урьдчилан Сэргийлэх тухай Хууль, 2019, https://www.legislationline.org/download/id/6035/file/Montenegro_law_on_the_prevention_of_money_laundering_2014_en.pdf.
- 31 “Олборлох Үйлдвэрийн Ил Тод Байдлын Санаачилгыг хэрэгжүүлэгч орон дахь эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах эрх зүйн аргачлалууд”, EITI, 15.
- 32 эцсийн өмчлөгчийн Бүртгэл: 2019 онд шинэчилсэн”, PWC.



- 33 “Олборлох Үйлдвэрийн Ил Тод Байдлын Санаачилгыг хэрэгжүүлэгч орон дахь эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах эрх зүйн аргачлалууд”, EITI, 15.
- 34 эцсийн өмчлөгчийн Бүртгэл: 2019 онд шинэчилсэн”, PWC.
- 35 Ibid.
- 36 Ibid.
- 37 Moran Harari, Andres Knobel, Markus Meinzer, and Miroslav Palanský, Өөр өөр төрлийн хуулийн бүтэц бүхий байгууллагын өмчлөлийн бүртгэлийн олон улсын туршлагын харьцуулалт: Эцсийн өмчлөлийн тоглоомын төлөв – 2020 онд шинэчилсэн, Tax Justice Network, 2020 оны 6-р сарын 1, 14, <https://www.taxjustice.net/wp-content/uploads/2020/06/State-of-play-of-beneficial-ownership-Update-2020-Tax-Justice-Network.pdf>.
- 38 Andres Knobel, эцсийн өмчлөгчийг баталгаажуулах нь: эцсийн өмчлөгчийн бүртгэл мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, Tax Justice Network, 2019 оны 1-р сарын 22, 34, https://taxjustice.net/wp-content/uploads/2020/11/Beneficial-ownership-verification_Tax-Justice-Network_Jan-2019.pdf.
- 39 Ibid.
- 40 Maria Eugenia Marano, Juan Argibay, and Adrián Falco, эцсийн өмчлөгчийн бүртгэл: A transversal demand (San Martín: Fundación SES, December 2020), 131, <http://www.conferenciabf.org/wp-content/uploads/2021/03/Beneficial-Ownership-Registration-web-2-1.pdf>.
- 41 “Олборлох Үйлдвэрийн Ил Тод Байдлын Санаачилгыг хэрэгжүүлэгч орон дахь эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах эрх зүйн аргачлалууд”, EITI, 15.
- 42 Harari et al., Өөр өөр төрлийн хуулийн бүтэц бүхий байгууллагын өмчлөлийн бүртгэлийн олон улсын туршлагын харьцуулалт: Эцсийн өмчлөлийн тоглоомын төлөв – 2020 онд шинэчилсэн, 15.
- 43 Tymon Kiepe, Victor Ponsford, and Louise Russell-Prywata, “эцсийн өмчлөгчийн Төрийн Бүртгэлийн эхэн үеийн нөлөө: Словак”, Нээлттэй Өмчлөл, 2020 оны 9-р сар, 3, <https://openownershipprod-1b54.kcdn.com/media/documents/oo-impact-story-slovakia-2020-09.pdf>.
- 44 Хуулийн этгээдүүдийн эцсийн өмчлөгчийн Сайн Туршлагауд, ФАТФ, 67.
- 45 Латвийн MONEYVAL дүгнэгчдэд зориулсан тайлан, нийтлэггүй, 2020.
- 46 Sébastien Guillaume and Alexandre Taymans, “Арагшаа болон урагшаа харах нь: Бельгийн эцсийн өмчлөгчийн Бүртгэлийн ирээдүйд дүн шинжилгээ хийх”, Belgium Treasury, 2021 оны 2-р сар, 16, https://finances.belgium.be/sites/default/files/thesaurie/20210208_LookingBackAndTheRoadAhead_Final.pdf.
- 47 “Авлигаас Урьдчилан Сэргийлэх Арга хэмжээ: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, тусгай зөвшөөрөл олгох, Төрийн худалдан авалтад эцсийн өмчлөгчийн мэдээллийг ашиглах нь”, Komisi Pemberantasan Korupsi.
- 48 Citizen TV Kenya (@citizentvkenya), “Joyce Koech – Компани бүртгэгч: компаниудын ердөө 33% нь бодит эцсийн өмчлөгчийн мэдээллийг өгсөн байна. Компаниуд ЭӨ-н мэдээллийг өгөхдөө e-платформруу шилжих ёстой #MondayReport @TrevorOmbija”, Twitter, 31 January 2022, 7:37 p.m., <https://twitter.com/citizentvkenya/status/1488235107462823937>.
- 49 Citizen TV Kenya, “MONDAY REPORT | GoK looking to establish true owners of Companies to avoid graft”, YouTube, 31 January 2022, <https://www.youtube.com/watch?v=nHuftmDCIdY>.
- 50 Knobel, эцсийн өмчлөгчийг баталгаажуулах нь: эцсийн өмчлөгчийн бүртгэл мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, 34.
- 51 Хуулийн этгээдүүдийн эцсийн өмчлөгчийн Сайн Туршлагауд, ФАТФ, 43.
- 52 EY доторх ЭӨ-н мэдээллийг бүртгүүлэхэд тавигдах шаардлага, KPMG International, 2019 оны 4-р сар, 52, <https://assets.kpmg/content/dam/kpmg/xx/pdf/2018/07/gls-transparency-register-web.pdf>.
- 53 “Төрийн Худалдан авалтыг өөрчлөх – Засгийн газраас зөвлөхөд өгсөн хариу”, UK Cabinet Office, 2021 оны 12-р сарын 6, <https://www.gov.uk/government/consultations/green-paper-transforming-public-procurement/outcome/transforming-public-procurement-government-response-to-consultation>.
- 54 Үз: Harari et al., Өөр өөр төрлийн хуулийн бүтэц бүхий байгууллагын өмчлөлийн бүртгэлийн олон улсын туршлагын харьцуулалт: Эцсийн өмчлөлийн тоглоомын төлөв – 2020 онд шинэчилсэн, 14; Knobel, эцсийн өмчлөгчийг баталгаажуулах нь: эцсийн өмчлөгчийн бүртгэл мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, 34.
- 55 Betty Santangelo, Joseph P. Vitale, Melissa G.R. Goldstein, and Kyle B. Hendrix, “FinCEN эцсийн өмчлөгчийн мэдээллийг мэдээлэхыг шаардсан Компаний Ил Тод Байдлын Хуулийг Хэрэгжүүлэхэд Журам гаргах процессийг эхлүүлээ”, Schulte Roth & Zabel, 26 April 2021, <https://www.srz.com/images/content/1/7/v2/178971/042621-SRZ-Alert-FinCEN-Commences-Process-For-Corporate-Transpar.pdf>.
- 56 Захирамж (EU) 2018/843 (AMLD5), Зүйл 30(a)(1).
- 57 EY доторх ЭӨ-н мэдээллийг бүртгүүлэхэд тавигдах шаардлага, KPMG International, 34.
- 58 “Журам 19 – Хязгаарлалт хийх мэдэгдлийн агуулга”, Нөлөө бүхий эзэмшигч этгээдүүдийн Бүртгэлийн журам 2016, <https://www.legislation.gov.uk/ukxi/2016/339/regulation/19/made>. Мөн дараахыг үзнэ үү: “Жагсаалт 1B – Мэдээллийг өгөх шаардлагыг мөрдүүлэх”, Компаний Хууль 2006, <https://www.legislation.gov.uk/ukpga/2006/46/schedule/1B>.
- 59 2021. évi XLIII. törvény a pénzügyi és egyéb szolgáltatók azonosítási feladatához kapcsolódó adatszolgáltatási háttér megteremtéséről és működtetéséről (Afad.), 22 May 2021, <https://njt.hu/jogszabaly/2021-43-00-00.0>; нэмэлт мэдээллийг дараахаас авна уу: Gábor Gelencsér and Judit Sós, “Эцсийн өмчлөгчийн бүртгэлийг танилцуулахтай холбоотой хураангуй”, Kinstellar, 2021 оны 7-р сар, <https://www.kinstellar.com/locations/news-deals-insights/detail/11/1492/summary-regarding-the-introduction-of-the-ultimate-beneficial-owners-registry>.
- 60 “Компаний Ил Тод Байдлын Хууль 2019”, part of the William M. (Mac) Thornberry National Defense Authorization Act for Fiscal Year 2021, Id. § 6403(c)(3)(A), <https://www.congress.gov/116/plaws/publ283/PLAW-116publ283.pdf>.
- 61 Үүний талаар дараахаас үзнэ үү: Ил тод байдал ба эцсийн өмчлөгч (Парис: ФАТФ, 2019 оны 10-р сар), 27, <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/Guidance-transparency-beneficial-ownership.pdf>, үүнд “дээд удирдлагын зөвлөлийн гишүүд нь компаниас тусгайлсан зөвшөөрөл авах үйлдэл нь өөрсдийнх нь эрх мэдэлд хамаарах тул ингэхийг хориглоно” гэж заасан байдаг.
- 62 Мөнгө Угаах, Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Олон Улсын Стандарт: ФАТФ-н Зөвлөмжүүд, ФАТФ, 93.



- 63 Хуулийн этгээдүүдийн эцсийн өмчлөгчийн Сайн Туршлагауд, ФАТФ, 23. Мөн дараахыг үзнэ үү: EITI Стандарт 2019, EITI, 2019 оны 10-р сарын 15, https://eiti.org/sites/default/files/attachments/eiti_standard_2019_en_a4_web.pdf. (EITI Стандарт Шаардлага 2.5-д ЭӨ-н мэдээллийг мэдээлэх оронд оршин суудаг эсэхийг заагаагүй ч ЭӨ-н мэдэгдлийг дээд удирдлагын баг эсвэл хуулийн дээд зөвлөлийн гишүүнээр гарын үсэг зуруулан баталгаажуулахыг зөвлөдөг).
- 64 Хууль. No. 315/2016 Coll. Төрийн Түншлэлийн Бүртгэл ба зарим Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь 2016 оны 10-р сарын 25-нд нэмэлт өөрчлөлт оруулсан, <https://www.slov-lex.sk/pravne-predpisy/SK/ZZ/2016/315/20191101>.
- 65 Ibid, Хэсэг 11(1).
- 66 Хуулийн этгээдүүдийн эцсийн өмчлөгчийн Сайн Туршлагауд, ФАТФ, 32.
- 67 Ibid, 67.
- 68 ЕХ доторх ЭӨ-н мэдээллийг бүртгүүлэхэд тавигдах шаардлага, KPMG International, 19.
- 69 Ibid, 7.
- 70 EY Global, “Колумб улс эцсийн өмчлөгчийн талаар журмандаа өөрчлөлт оруулаа”, 4 April 2022, https://www.ey.com/en_gl/tax-alerts/colombia-modifies-regulations-on-ultimate-beneficial-owners
- 71 FinCEN, “эцсийн өмчлөгчийн Мэдээллийг мэдээлэхэд тавигдах шаардлага”, Proposed rule, 86 FR 69920, 2021 оны 12-р сарын 8, <https://www.federalregister.gov/documents/2021/12/08/2021-26548/beneficial-ownership-information-reporting-requirements>.
- 72 Бизнесийн Бүртгэлийн Үйлчилгээ, “НИЙТЭД МЭДЭЭЛЭХ НЬ - эцсийн өмчлөгчийн Е-БҮРТГЭЛИЙН ЯВЦЫН МЭДЭЭ - 2021 ОНЫ 7-Р САРЫН 30”, 2021 оны 7-р сарын 30, https://brs.go.ke/assets/downloads/BENEFICIAL_OWNERSHIP_E_REGISTER_PROGRESS_UPDATE%20_30TH_JULY_2021_V3_FINAL.pdf.
- 73 Кiere, “эцсийн өмчлөгчийн Мэдээллийг Баталгаажуулах нь”, 10.
- 74 Мөнгө Угаах, Терроризмыг Санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээнүүд: Мальта – Хамтын Үнэлгээний 5-р Тайлан, (Strasbourg: MONEYVAL Secratariat, 2019 оны 7-р сар), 185, <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/mer-fsrb/Moneyval-Mutual-Evaluation-Report-Malta-2019.pdf>; Мөнгө Угаах, Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх арга хэмжээнүүд: Мальта – 1-р Сайжруулсан Нэхэлт Тайлан (Strasbourg: MONEYVAL Secratariat, 2021 оны 4-р сар), 9, <https://rm.coe.int/moneyval-2021-7-fur-malta/1680a29c70>.
- 75 Abschnitt 7, §56.3.1, Geldwäschegesetz, https://www.gesetze-im-internet.de/gwg_2017/.
- 76 Хуулийн этгээдүүдийн эцсийн өмчлөгчийн Сайн Туршлагауд, ФАТФ, 66.
- 77 Ibid.
- 78 Ibid, 67.
- 79 Хилийн чанадын байгууллагуудын бүртгэлийн хуулийн төсөл дээрх Хамтын Комисс: Бичигдсэн Баримтуудын Харьцуулалтын Боть, House of Lords and House of Commons, 2019 оны 3-р сар, <https://www.parliament.uk/globalassets/documents/joint-committees/draft-registration-overseas-entities/ROEB-written-evidence-volume.pdf>.
- 80 Хуулийн этгээдүүдийн эцсийн өмчлөгчийн Сайн Туршлагауд, ФАТФ, 67.
- 81 Ibid, 65.
- 82 Ibid, 65-66.
- 83 Ibid, 68.
- 84 Ibid.
- 85 Emile van der Does de Willebois, Emily M. Halter, Robert A. Harrison, Ji Won Park, and J.C. Sharman, Утсан Хүүхэлдээний Эзэд: Авлига авагчид Хуулийн Бүтцийг ашиглан хэрхэн Хулгайлсан Хөрөнгөө Нуудаг вэ болон энэ талаар юу хийх ёстой вэ (Washington DC: Дэлхийн Банк, 2011), 75, <https://star.worldbank.org/sites/star/files/puppetmastersv1.pdf>.
- 86 Ibid, 73.
- 87 Үз: “Компаний Ил Тод Байдал ба Бүртгэлийн Шинэчлэл: Бүртгэгчийн Эрх Мэдэл”, Бизнес, Эрчим хүч, Үйлдвэрийн Стратегийн Хэлтэс, 2020 оны 12-р сар, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/942167/Registrar_s_Powers_Consultation.pdf.
- 88 Knobel, эцсийн өмчлөгчийг баталгаажуулах нь: эцсийн өмчлөгчийн бүртгэл мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, 17.
- 89 Мөнгө Угаах, Терроризмыг Санхүүжүүлэхтэй Тэмцэх Олон Улсын Стандарт: ФАТФ-н Зөвлөмжүүд, ФАТФ, 25.
- 90 Үз: “Хөдөлмөрийн зах зээлийн дүрмийг зөрчсөн компаниудыг засгийн газраас зарлан буруутгах нь тодорхой нөлөө үзүүлэх ч илүү чанга мөрдүүлэлт, өндөр торгууль тавих ёстой”, Resolution Foundation, 2021 оны 11-р сарын 9, <https://www.resolutionfoundation.org/press-releases/government-publicly-naming-and-shaming-firms-breaking-labour-market-rules-has-some-effect-but-must-be-higher-profile-and-complemented-by-tougher-enforcement-and-larger-fines/>.
- 91 Үз: “Төлбөрөө хоцорч төлдөг харилцагчдыг зарлан буруутгах нь хэрэг болдог уу?”, Hilton-Baird Collection Services, 2020 оны 1-р сарын 28, <https://www.hiltonbairdcollections.co.uk/does-naming-and-shaming-customers-who-pay-late-actually-work/>.
- 92 Үз: “AMCON: Зээлээ хоцорч төлөгсдийн эсрэг хэвлэл мэдээллийн дайн эрчээ авсан нь”, THISDAY, 2021 оны 12-р сарын 12, <https://www.thisdaylive.com/index.php/2021/12/12/amcon-as-media-war-against-delinquent-debtors-gathers-steam/>; “Зарлан Буруутгах бас нэг оролдлого”, InvestAdvocate, 5 January 2022, <https://investadvocate.com.ng/2022/01/05/another-attempt-at-naming-and-shaming/>.
- 93 Abschnitt 7, §56, Geldwäschegesetz, https://www.gesetze-im-internet.de/gwg_2017/; ЕХ доторх ЭӨ-н мэдээллийг бүртгүүлэхэд тавигдах шаардлага, KPMG International, 7.
- 94 Хуулийн этгээдүүдийн эцсийн өмчлөгчийн Сайн Туршлагауд, ФАТФ, 66.
- 95 ЕХ доторх ЭӨ-н мэдээллийг бүртгүүлэхэд тавигдах шаардлага, KPMG International, 34.
- 96 “Компаний Хэлтсийн Статистик”, Компаний Хэлтэс, n.d., <https://www.gov.uk/government/organisations/companies-house/about/statistics>.
- 97 Хуулийн этгээдүүдийн эцсийн өмчлөгчийн Сайн Туршлагауд, ФАТФ, 66.
- 98 Ibid.
- 99 Үз: Кiere, “эцсийн өмчлөгчийн мэдээллийг баталгаажуулах нь”.
- 100 эцсийн өмчлөгчийг хэрэгжүүлэх цогц багаж хэрэгслүүд(Парис: OECD and the Inter-American Development Bank, 2019 оны 3-р сар), 37, <https://www.oecd.org/tax/transparency/beneficial-ownership-toolkit.pdf>.



- 101 Үз: “Компаний Ил Тод Байдал ба Бүртгэлийн Шинэчлэл: Бүртгэгчийн хүч”, Бизнес, Эрчим хүч, Үйлдвэрийн Стратегийн Хэлтэс.
- 102 Хуулийн этгээдүүдийн эцсийн өмчлөгчийн Сайн Туршлагауд, ФАТФ, 46.
- 103 Үз: “Хилийн чанадын байгууллагын бүртгэлийн хуулийн төсөл: Хурлын тайлан 2017-2019”, House of Lords, House of Commons, and Joint Committee on the Draft Registration of Overseas Entities Bill, 2019 оны 5-р сарын 20, 40-42, <https://www.parliament.uk/globalassets/documents/joint-committees/draft-registration-overseas-entities/Report.pdf>; “Нөлөө бүхий эзэмшигч этгээдүүдийн бүртгэлийн хэрэгжүүлэлтийн хянан нягтлалт: BEIS Судалгааны Нийтлэлийн Дугаар 2019/005” Бизнес, Эрчим хүч, Үйлдвэрийн Стратегийн Хэлтэс, 2019 оны 3-р сар, 35, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/822823/review-implementation-psc-register.pdf.
- 104 Кiere, Ponsford, and Russell-Prywata, “эцсийн өмчлөгчийн Төрийн Бүртгэлийн эхэн үеийн нөлөө: Словак”, 3.

Зохиогчид

Ramandeep Kaur Chhina

Tymon Kiere

хувь нэмэр оруулсан

Alanna Markle

Favour Ime

Karabo Rajuili

Peter Low

Редактор

Cara Marks

Хянагчид

Michael Barron

Tim Law

Орчуулагч


Albourn Translation Services

Загвар

Convincible Media

Нийтэлсэн

openownership.org

 @openownership

c/o Global Impact, 1199 North Fairfax Street, Suite 300, Alexandria, VA 22314, USA

**Open
Ownership**

